



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



UN
DP



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОЙ
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ



БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

Тайланг боловсруулсан:

Ж.Ганбаатар, зөвлөх

Г.Амаржаргал, зөвлөх

Хянан тохиолдуулсан:

Т.Батсүх, Сангийн яамны зөвлөх

С.Мөнх-Эрдэнэ, Биеийн тамир, спортын улсын хорооны ахлах мэргэжилтэн

Энэхүү “Биеийн тамир, спортын салбарын төсвийн зарлагын шинжилгээ” судалгааны тайланг Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий зүйл

ISBN 978-9919-9059-7-2

Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хариуцлага хүлээхгүй болно. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС	6
ОРШИЛ	7
1. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ	8
1.1. Төсвийн зарлагын шинжилгээ зорилго	8
1.2. Зарлагын шинжилгээний хамрах хүрээ	8
1.3. Зарлагын шинжилгээний арга зүй	8
2. БИЕЙН ТАМИРЫН САЛБАРЫН УРТ БА ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	9
2.1. Биеийн тамирын салбарын урт ба дунд хугацааны бодлогууд	9
2.2. Салбарын эрх зүйн орчин	9
2.3. Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилго 2030 ба биеийн тамирын салбарын бодлогын уялдаа	11
3. БИЕЙН ТАМИРЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, БҮТЭЦ	12
3.1. Биеийн тамирын салбарын байгууллага болон ажиллагчид	13
3.2. Спортын барилга, байгууламж	14
3.3. Тамирчид, шүүгчид	15
4. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА, БОДЛОГЫН УЯЛДАА	16
4.1. Салбарын төсвийн зарлагын макро үзүүлэлтүүд	19
4.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр ба ТЕЗ-ийн төсвийн үр дүн	19
5. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ТӨСВИЙН НАЙДВАРТАЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	20
5.1. Нийт зарлагын гүйцэтгэл	24
5.2. Төсвийн зарлагын гүйцэтгэл, зардлын ангиллаар	25
5.3. Төсвийн орлогын гүйцэтгэл	26
6. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХӨТӨЛБӨР, ЗОРИУЛАЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ	29
7. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН УРСГАЛ БА ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ЧИГ ХАНДЛАГА, ХУВААРИЛАЛТ	31
7.1. Салбарын нийт төсвийн зарлагын хуваарилалт	36
7.2. Салбарын урсгал зардлын бүтэц	37
7.2.1. Салбарын урсгал зардалд цалин хөлсний зардлын эзлэх харьцаа	40
7.2.2. Салбарын урсгал зардалд тогтмол зардлын эзлэх харьцаа	41
7.3. Салбарын хөрөнгийн зардлын чиг хандлага	41
8. ТӨСВИЙН ХАНГАЛТТАЙ БАЙДАЛ	46
9. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ	47
10. ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ	53
11. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	54
12. ДҮГНЭЛТ	68
13. ЗӨВЛӨМЖ	71
АШИГЛАСАН НОМ ЗҮЙ	72

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх	10
таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ	
Хүснэгт 2. Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтээс	11
Хүснэгт 3. Биеийн тамирын салбарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль,	12
захирамж	
Хүснэгт 4. Харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагч	19
Хүснэгт 5. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны	20
хөтөлбөрийн хэрэгжилт хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	
Хүснэгт 6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр,	20
хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт	
Хүснэгт 7. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчдын мэдээ	22
Хүснэгт 8. Нэг хүн амд ногдох зардал /мян.төг/	22
Хүснэгт 9. Нийт зарлагын батлагдсан төсөв ба гүйцэтгэл /сая.төг/	25
Хүснэгт 10. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2020 он	26
Хүснэгт 11. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2021 он	26
Хүснэгт 12. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2022 он	26
Хүснэгт 13. Салбарын төсөв ба гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар (сая төгрөгөөр)	27
Хүснэгт 14. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2020 он	28
Хүснэгт 15. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2021 он	28
Хүснэгт 16. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2022 он	29
Хүснэгт 17. Нийт орлогын гүйцэтгэл, мян төгрөгөөр	30
Хүснэгт 18. Хөтөлбөрийн ангиллын харьцуулалт	31
Хүснэгт 19. Салбарын зарлагын гүйцэтгэл, хөтөлбөрөөр, сая төгрөгөөр	32
Хүснэгт 20. Салбарын төсвийн зарлагын хөтөлбөр, зардлын зориулалт, арга	32
хэмжээний ангиллаар /сая. төг/	
Хүснэгт 21. Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын гүйцэтгэл, сая төгрөгөөр	34
Хүснэгт 22. Цалин хөлсний зөрүү (мянган төг.)	41
Хүснэгт 23. Хөрөнгө оруулалтын төсөв ба гүйцэтгэл /сая.төг/	42
Хүснэгт 24. Хөрөнгө оруулалт байгууллагын төрлөөр	42
Хүснэгт 25. Хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэл, оноор	43
Хүснэгт 26. Хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэл, 5-аас дээш жил	44
Хүснэгт 27. Биеийн тамир, спорт хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур	48
үзүүлэлтүүд	
Хүснэгт 28. Биеийн тамир, спорт хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур	50
үзүүлэлтүүд	
Хүснэгт 29. Хамаарлын шинжилгээ	51
Хүснэгт 30. Хамаарлын шинжилгээнд хэрэглэсэн үзүүлэлт /сая төгрөгөөр/	52

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Биеийн тамир спортын байгууллагын тоо	14
Зураг 2. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчдын тоо, хүйс, оноор	14
Зураг 3. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчид, албан тушаалын төрөл, хувиар, 2023 он	15
Зураг 4. Спортын барилга, өссөн дүнгээр	15
Зураг 5. Спортын барилга, өссөн дүнгээр	16
Зураг 6. Шинээр ашиглалтад орсон спортын барилга, байгууламж, дүнд эзлэх хувиар, 2022 он	16
Зураг 7. Шинээр ашиглалтад орсон спортын гадаа талбай, төрөл, дүнд эзлэх хувиар, 2022 он	17
Зураг 8. Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо, бүсээр, 2022 он	17
Зураг 9. Нийт цол, зэрэг авсан тамирчдын тоо, хүйс, оноор	18
Зураг 10. Шүүгчийн тоо, төрлөөр, оноор	18
Зураг 11. Салбарын төсвийн зарлагын ДНБ ба улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь /тэрбум төг./	20
Зураг 12. Салбарын батлагдсан төсөв, гүйцэтгэл /тэрбум.төг/	24
Зураг 13. Төсвийн зарлагын гүйцэтгэл, жилийн өсөлтийн хувь /тэрбум төг./	24
Зураг 14. Биеийн тамир, спортын арга хэмжээ, зарлагын төрлөөр, сая төгрөгөөр	33
Зураг 15. Урсгал ба хөрөнгийн зардлын жилийн өсөлт, хувиар	35
Зураг 16. Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлд урсгал ба хөрөнгийн зардлын эзлэх хувь	36
Зураг 17. Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын төсвийн гүйцэтгэлийн хувь	36
Зураг 18. Нийт төсвийн зарлагын хуваарилалт, 2022 он	37
Зураг 19. Урсгал төсвийн зарлагын хуваарилалт, 2022 он	37
Зураг 20. Салбарын урсгал зардлын бүтэц /хувиар/	37
Зураг 21. Салбарын бараа үйлчилгээний зардлын бүтэц, хувиар	38
Зураг 22. Бараа үйлчилгээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт	39
Зураг 23. Харьяа байгууллагын ажилтны дундаж цалин хөлс, мянган төгрөгөөр	40
Зураг 24. Биеийн тамир, спорт ба бусад салбарын цалин хөлс, мянган төгрөгөөр	40
Зураг 25. Салбарын зарим зардлын харьцаа, мянган төгрөгөөр	41
Зураг 26. 2010-2022 онд баригдсан барилгын тоо, зориулалтаар	46
Зураг 27. Салбарын нийт өр төлбөр ба авлага, сая төгрөгөөр	47

ТОВЧИЛСОН ҮГС

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
МУ	Монгол Улс
ЕХ	Европын Холбоо
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТЭСХ	Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлага
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮДСТТ	Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагууд
БТСГ	Биеийн тамир, спортын газар
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо



НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж байна. Сангийн яам нь энэхүү төслийн “А” бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн дэмжлэгийн хүрээнд Монгол Улсад бодлого ба төсвийн уялдааг хангах, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг ТХЗ-ын тэргүүлэх салбар, хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх, дунд хугацааны зарлагын хүрээнд шилжих бодлогын хувилбарыг тодорхойлохоор ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн 2023 оны төсвийн төслийг үр дүнд суурилсан төсөвлөлтийн аргачлалаар боловсруулж, амжилттай туршиж, төсвийг батлуулсан.

Цаашид ТХЗ-ын тэргүүлэх салбаруудын хөтөлбөрийн бодлого, төсвийг уялдуулан үр дүнд суурилсан төлөвлөлтөд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, нотолгоонд суурилсан төсөв боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор биеийн тамир, спортын салбарын хөтөлбөрт институцийн болон зарлагын шинжилгээг дотоодын зөвлөхүүдийн тусламжтайгаар хийлээ. Энэхүү зарлагын шинжилгээнд биеийн тамир, спортын салбарын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс зарцуулсан төсвийн зарлагын хэмжээ, өсөлт, бууралтад нөлөөлж буй гол хүчин зүйлс, салбарын төсвийн хуваарилалт, төсвийн зардлын үр өгөөжийг тодорхойлж, төсвийн найдвартай байдлын үнэлгээг хийсэн бөгөөд цаашид тус салбарт зарцуулж байгаа төсвийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр бодлогын зөвлөмжийг орууллаа.

Тайланг боловсруулахад санхүүгийн болон статистик тоо мэдээллээр хангаж хамтарч ажилласан Засгийн газрын тохируулагч агентлаг, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын үүрэг гүйцэтгэгч О.Баттулга, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл, ахлах мэргэжилтэн С.Мөнх-Эрдэнэ, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Эрдэнэцогт, төсвийн ерөнхий нягтлан бодогч А.Өнөрцэцэг, “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн зөвлөхүүдэд талархлаа илэрхийлэе.

САНГИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР

1. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

1.1. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ ЗОРИЛГО

Биеийн тамир, спортын салбарын төсвийн зарлагын шинжилгээний зорилго нь салбарын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс зарцуулсан төсвийн зарлагын хэмжээ, чиг хандлага, төсвийн ил тод, найдвартай байдал, төсвийн хуваарилалт ба бодлогын уялдаа, биеийн тамир, спортын үйлчилгээний төсвийн үр өгөөжид дүн шинжилгээ хийж Биеийн тамир, спортын улсын хороо болон СЯ-ны бодлого боловсруулагч, мэргэжилтнүүдэд бодлогын санал дэвшүүлэх, зөвлөмж өгөх зорилготой.

Түүнчлэн энэхүү дүн шинжилгээгээр салбарын төсвийг бодлогын зорилттой уялдуулан үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт (ҮДСТТ)-ийн аргачлалаар төлөвлөдөг зарчимд шилжихийн тулд хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, урьдчилсан нөхцөлийг тодорхойлох зорилготой болно.

1.2. ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү сэдэвчилсэн зарлагын шинжилгээнд тус салбарт 2012-2022 онд улсын төсвөөс баталсан нийт төсөв, түүний зарцуулалт, урсгал ба хөрөнгийн зардал, урсгал зардлын бүтцийн шинжилгээг хамруулна. Салбарын төсвийн найдвартай байдлыг үнэлэхдээ олон улсын аргачлалын дагуу сүүлийн 3 жилийн буюу 2020-2022 оны төсвийн мэдээлэлд үндэслэсэн болно.

Энэхүү зарлагын шинжилгээнд тус салбарын 33 байгууллагын төсөв ба гүйцэтгэлийн мэдээг хамруулсан болно. Биеийн тамир, спортын салбарт ажиллагч төрийн албан хаагчдын 2012-2022 оны тоо, мэдээллийг энэхүү шинжилгээнд хамрууллаа.

1.3. ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Биеийн тамир, спортын салбарын төсвийн зарлагын шинжилгээнд хүчин зүйлсийн хамаарлын регрессийн шинжилгээ, энгийн нийцлийн шинжилгээ, чиг хандлагын шинжилгээ, болон дүн шинжилгээний бусад арга зүйг ашиглалаа. Түүнчлэн салбарын урт ба дунд хугацааны бодлого, хууль эрх зүйн орчин, дотоод, гадаадын судалгааны байгууллага, судлаачдын боловсруулсан ном, тайлангуудыг уншиж судлан бусад орнуудын орчин үеийн чиг хандлагыг манай өнөөгийн нөхцөл байдалтай харьцуулан дүгнэлт хийв.

Түүнчлэн салбарын статистикийн тоон ба чанарын өөрчлөлтийн үзүүлэлтүүдийг харьцуулах, хүчин зүйлүүд ба үзүүлэлтийн хамаарлыг графикаар илэрхийлэх арга зүйг ашигласан болно. Энэхүү шинжилгээний хүрээнд асуудал хариуцсан төрийн байгууллагын ажилтнууд, орон нутгийн байгууллагын төлөөлөгчидтэй санал солилцох уулзалт, ярилцлагууд хийж, дүгнэлт хийлээ.

2.

БИЕИЙН ТАМИРЫН САЛБАРЫН УРТ БА ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

2.1. БИЕИЙН ТАМИРЫН САЛБАРЫН УРТ БА ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГУУД

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-д нийгэм, соёл, эдийн засаг, байгаль орчны асуудлыг цогцоор нь авч үзэн, хөгжлийн үр шимийг иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүргэх зарчмыг баримтлан бүх салбарын оролцоог ханган, тогтвортой хөгжлийн үндсийг хангахад чиглэсэн.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Амьдралын чанар ба дундаж давхарга” гуравдугаар бүлгийн **“Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, идэвхтэй бүтээлч гэр бүлийг төлөвшүүлэн, хэрэгцээндээ нийцсэн байр сууц бүхий, хөрөнгө оруулалтын таатай орчин, нөхцөлд өрсөлдөхүйц бичил, жижиг, дунд бизнес эрхлэн өрх, гэр бүл, өөрийгөө тэтгэн амьдрах боломжтой, сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг бүрдүүлнэ.”** гэж тусгасан ба тэр дундаа Эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг **“Зорилт 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ”** гэж заасан байгаа. Түүнчлэн тус зорилтыг хэрэгжүүлэх 3 үе шат, хүрэх үр дүнг 2021-2050 оны хугацаанд тодорхойлсон байна.

Хүснэгт 1. “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” (2020.05.13)	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020.08.28)
АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг
Эрүүл идэвхтэй амьдралын хэв маяг	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг
Зорилт 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн: I үе шат (2021-2030): Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх үе. 1. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн	Зорилт 3.5. Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ: 3.5.1. Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ. 3.5.2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ. 3.5.3. Нийтийн биеийн тамирыг эрүүл,

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” (2020.05.13)

түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.

2. Биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоо боловсронгуй болсон байна.

3. Биеийн тамир, спортын салбарт цахим үйлчилгээ нэвтэрч, үндэсний нэгдсэн мэдээллийн сан бүрдсэн байна.

4. Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийн хөгжил, чадавхжуулалт, дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

II үе шат (2031-2040):

Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх биеийн тамир, спортын чанар, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх үе.

1. Идэвхтэй амьдралын дадал хэвшлийг дэмжих тогтолцоо бүрдэж, хот, суурин газрын орон сууцны хотхон, хорооллын төлөвлөлтөд биеийн тамир, спортоор хичээллэх, амьдралын зөв дадал хэвшилтэй болгох олон улсын стандарт, шаардлагад нийцсэн, тохилог, таатай орчныг бий болгоно.

2. Амьдрал, ажил, мэргэжлийн хэв маяг, агуулгын өөрчлөлттэй холбоотойгоор биеийн тамир, спортын тэргүүлэх чиглэлийг хөгжүүлж, авьяасыг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

III ҮЕ ШАТ (2041-2050):

Биеийн тамир, спортын идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүл төлөвших үе.

3. Биеийн тамир, спортоор хичээллэх өдөр тутмын амьдралын идэвхтэй дадал хэвшилтэй иргэн, гэр бүлийг төлөвшүүлэхэд хиймэл оюун ухаанд тулгуурласан технологи, үйлчилгээг нэвтрүүлнэ.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020.08.28)

идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.

3.5.4. Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилт дээшилсэн байна.

3.5.5. Хоол, хүнсний тухай боловсрол олгох талаар сургалтын хөтөлбөрт тусгана.

“Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг цогцлоох” гэсэн нэгдүгээр бүлгийн зорилгод хүрэх үр дүнг хүснэгт 2-т заасан дараах 3 шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлжээ.

Хүснэгт 2. Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлтээс

	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин			Тайлбар
				2025	2030	2050	
	Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар)	хувь	53	60	65	99	Сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулж 100-гаар үржүүлнэ

УИХ-ын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт биеийн тамирын салбарт дараах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

“БИЕИЙН ТАМИР, СПОРТ”

2.2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

2.2.1. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ.

2.2.2. Монгол үндэсний уламжлалт спортыг дэлхий нийтэд таниулахад төрөөс бодлогоор дэмжиж, үндэсний спортын төв байгуулж, гадаад улсын баг тамирчдыг оролцуулах тэмцээн, наадмын тогтолцоог хөгжүүлнэ.

2.2.3. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина.

2.2. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Биеийн тамирын салбарт дараах хууль, захирамж хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

Хүснэгт 3. Биеийн тамирын салбарт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль, захирамж

Хууль, захирамжийн нэр	Батлагдсан огноо	Зорилго
Биеийн тамир, спортын тухай хууль	2017.07.06	Биеийн тамир, спортын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх зүйн үндсийг тодорхойлж, биеийн тамир, спортыг хөгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.
Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг	2010.03.26	Хүүхэд, залуучуудыг нийтийн биеийн тамираар хичээллүүлэх, эрүүл чийрэг бие бялдар, өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, олимп, тив, дэлхийн спортын уралдаан, тэмцээнд амжилттай оролцох баг, тамирчдыг бэлтгэх үндсийг бий болгох

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай” зарлигт ийнхүү тусгасан байна:

1. Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор “Хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүрийн дөрөвдүгээр сард явуулж, үнэлэлт, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон.

2. Биеийн тамир, спортыг нийтийн үйл хэрэг болгох зорилгоор дунд болон их, дээд сургуулиудад биеийн тамир, спортыг сургалтын тэргүүлэх чиглэл болгож, сурагч, оюутнуудыг спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах, спортын хамтлаг, клубийн тогтолцоог нэвтрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, тамирчид, багш дасгалжуулагчид, бизнесийн бүх байгууллага, нийт ард иргэдэд уриалсан.

2.3. ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 2030 БА БИЕИЙН ТАМИРЫН САЛБАРЫН БОДЛОГЫН УЯЛДАА

Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг 2015 оны 9 дүгээр сард баталж, хөгжлөөс “хэнийг ч үл орхих” гэсэн зарчимтайгаар байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалж, хүний эрхийг дээдлэн, байгалийн нөөцийг зохистой ашиглаж, хөгжил цэцэглэлтийг бий болгож, нийгэм, эдийн засаг зэрэг бүх салбарыг тэгш хөгжүүлэх зорилго дэвшүүлсэн.

Дэлхийн “Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-ын зорилтуудын ойролцоогоор 80 хувь нь Алсын хараа 2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн

зорилт, арга хэмжээтэй уялдаатай байна гэж дүгнэсэн байдаг.¹ Тухайлбал, Тогтвортой хөгжлийн нийт 169 зорилтын 116 зорилт нь Алсын хараа 2050-тай бүрэн уялдаатай, 24 зорилттой нь агуулгаараа уялдаатай, 12 зорилт нь огт тусаагүй, 13 зорилт нь манай оронд шууд хамааралгүй, 4 зорилт нь бүрэн хэрэгжсэн байна гэж дүгнэсэн. Харин Тогтвортой хөгжлийн зорилгын 244 шалгуур үзүүлэлтийн 20 шалгуур үзүүлэлтийг буюу дөнгөж 8% нь манай хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд ашиглагдсан байна.

Тогтвортой хөгжлийн 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлтэд спорт, идэвхтэй хөдөлгөөнтэй шууд холбогдох үзүүлэлт байхгүй ба Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягт Зорилт 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийн дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ гэж тусгасан байна.


¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (2021). Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг болон Тогтвортой хөгжлийн зорилго хоорондын уялдаа, тойм шинжилгээ: Үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж. [undp-mapping-SDGs-2021-mongolian-version.pdf](#)

3. БИЕЙН ТАМИРЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, БҮТЭЦ

3.1. БИЕЙН ТАМИРЫН САЛБАРЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН АЖИЛЛАГЧИД

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар биеийн тамир, спортын 33 байгууллагад, 861 хүн ажиллаж байна. Ажиллагчдын тоо өмнөх оноос 91 (11.8%)-оор нэмэгдсэн байна. Нийт ажиллагчдын 58 хувь нь эрэгтэйчүүд байна.


Зураг 1. Биеийн тамир спортын байгууллагын тоо



Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn, 2023

Нийт ажиллагчид болон байгууллагын тоо өмнөх оноос өссөн гол шалтгаан нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороог байгуулах тушаалаар Биеийн тамир, спортын улсын хороог байгуулсантай холбоотой юм.


Зураг 2. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчдын тоо, хүйс, оноор



Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn, 2023

Нийт ажилчдын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд 704-861 хооронд хэлбэлзсэн ба нийт эмэгтэй ажилчдын тоо тогтмол өссөн үзүүлэлтэй байна. Эмэгтэй ажилчдын эзлэх хувь 2018 онд 30.5% байсан бол 2020 онд 42% болж 11.5 хувиар өссөн байна. /Зураг 3/

Зураг 3. Биеийн тамир, спортын байгууллагад ажиллагчид, албан тушаалын төрөл, хувиар, 2023 он




Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn, 2023

Нийт ажиллагчдыг албан тушаалын төрлөөр харвал 297 (34.5%) нь үйлчилгээ, аж ахуйн ажилтан, 160 (18.6%) нь мэргэжилтэн, 139 (16.1%) нь дасгалжуулагч, 102 (11.8%) нь захиргаа санхүүгийн ажилтан, 72 (8.4%) нь удирдах ажилтан, 61 (7.1%) нь биеийн тамирын арга зүйч, 15 (1.7%) нь эмч, 15 (1.7%) нь бусад мэргэжилтэн байна.

3.2. СПОРТЫН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

Монгол Улсад 2022 онд биеийн тамир, спортын 42 барилга шинээр ашиглалтад орж нийт заалны тоо 1166 болсон байна. Биеийн тамир, спортын улсын анхдугаар тооллогын үеэр нийт 985 заал тоологдсоноос хойш тайлангийн хугацаанд нийт 18.4%-иар нэмэгдсэн байна. Биеийн тамир, спортын барилга нь хэд хэдэн төрлөөс бүрдэх бөгөөд нийт тооны дийлэнх хувийг “спорт заал” эзэлж байгааг доор зургаас харах боломжтой. Хэвийн үйл ажиллагаа явуулж буй 1,166 заалны 854 (73.2%) нь “спорт заал” төрөлд хамаарч байна.


Зураг 4. Спортын барилга, өссөн дүнгээр



Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn,

Биеийн тамир, спортын зориулалт бүхий 65 гадаа талбай 2022 онд ашиглалтад орж нийт гадаа талбайн тоо 999 болсон байна. Биеийн тамир, спортын улсын анхдугаар тооллогын үеэр нийт 777 гадаа талбай тоологдсоноос хойш тайлангийн хугацаанд нийт 28.9 хувиар нэмэгдсэн байна.


Зураг 5. Спортын барилга, өссөн дүнгээр



Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn, 2023

2022 онд Монгол Улсын хэмжээнд 42 спортын барилга ашиглалтад орсон бөгөөд үүний 25 (59.5%) нь спортын заал, 9 (21.4%) нь бэлтгэлийн заал, 4 (9.5%) нь бусад байгууламж, 3 (7.1%) нь спортын ордон, 1 (2.4%) нь усан бассейн байна. /Зураг 5/


Зураг 6. Шинээр ашиглалтад орсон спортын барилга, байгууламж, дүнд эзлэх хувиар, 2022 он



Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn, 2023

2022 онд Монгол Улсын хэмжээнд 65 спортын гадаа талбай ашиглалтад орсон бөгөөд үүний 49 (75.4%) нь спортын гадаа талбай, 6 (9.2%) нь явган алхалт, аяллын зам, 4 (6.2%) нь бусад байгууламж, 2 (3.1%) нь цэнгэлдэх хүрээлэн, 2 (3.1%) нь дугуйн зам, 2(3.1%) нь цанын бааз байна. /Зураг 7/


Зураг 7. Шинээр ашиглалтад орсон спортын гадаа талбай, төрөл, дүнд эзлэх хувиар, 2022 он



Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn, 2023

3.3. ТАМИРЧИД, ШҮҮГЧИД


Зураг 8. Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо, бүсээр, 2022 он



Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn, 2023

Монгол Улсын хэмжээнд 2022 онд 3,795 тамирчин спортын цол авсан нь өмнөх онтой харьцуулахад 2,373-аар өссөн байна. 2022 онд шинээр цол авсан тамирчдын 1,053 (27.7%) нь эмэгтэй тамирчид байна. Цол авсан тамирчдыг цолны төрлөөр харвал 313 (8.2%) нь олон улсын хэмжээний мастер, 1,302 (34.3%) нь спортын мастер, 1,076 (28.4%) нь дэд мастер цолтой тамирчид байна.


Зураг 9. Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо, бүсээр, 2022 он



Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn, 2023

2022 онд нийт 164 шүүгч байгаагаас 61 (37.2%) нь эмэгтэй шүүгч байна. Нийт шүүгчдээс 22 (13.4%) нь олон улсын шүүгч 142 (86.6%) нь улсын шүүгчид байна.

Зураг 10. Шүүгчийн тоо, төрлөөр, оноор



Эх сурвалж: Биеийн тамир спортын улсын хороо, www.sport.gov.mn, 2023

4. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА, БОДЛОГЫН УЯЛДАА

Тухайн салбарыг сэдэвчилсэн байдлаар бодлогын хэрэгжилтийн үр ашиг, үр дүнг тодорхойлох зорилгоор, салбарын батлагдсан төсөв болон гүйцэтгэлийн 2012-2022 оны үзүүлэлтийг ашиглан шинжилгээ хийлээ. Шинжилгээнд хамаарлын болон зардлын харьцуулалт, энгийн индуктив аргуудыг хэрэглэсэн болно.

4.1. САЛБАРЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН МАКРО ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Салбарын зарлагын макро үзүүлэлтийг тухайн салбарын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн нийт дүнгээр үзүүлэв. Үзүүлэлтэд салбарын 2012-2022 оны төсвийн гүйцэтгэлийг хамруулсан болно.²

Биеийн тамир, спортын салбар нь тухайн тайлант хугацаанд дөрвөн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд төсөв нь батлагдаж, гүйцэтгэлээ тайлагнаж ирсэн байна. Өөрөөр хэлбэл соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд гэсэн нийт 3 салбартай хамт биеийн тамир, спортын салбарын эрхлэх асуудал хамрагдаж ирсэн байна. Энэ нь тухайн салбартай холбоотой төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг боловсруулахад хүндрэлтэй байв.

Хүснэгт 4. Харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагч

Салбар	Харьяалах Төсвийн ерөнхийлөн захирагч	Он	
Биеийн тамир, спорт	Соёл, Спорт, Аялал жуулчлалын яам	2012	2014
	Эрүүл мэндийн яам /ЭМЯ/	2014	2016
	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам /БСШУСЯ/	2016	2020
	Биеийн тамир, спортын хороо /Ерөнхий сайд/	2020	2023
	Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга	2023	2024

Биеийн тамир, спортын салбарын батлагдсан төсвийн гүйцэтгэлийн ерөнхий чиг хандлагыг ДНБ-д болон улсын төсвийн гүйцэтгэлд харьцуулан дүн шинжилгээ хийв. Биеийн тамир, спортын салбарын батлагдсан төсвийн гүйцэтгэл 2012 онд 63.8 тэрбум төгрөг байсан бол 2022 онд гүйцэтгэл 61.8 тэрбум төгрөг болсон байна. Салбарын төсвийн зарлагыг ДНБ-тэй харьцуулахад 2012 онд 0.4 хувь байсан бол 2022 онд 0.1 хувь болж 0.3 нэгжээр буурсан байна. /Зураг 10/ Салбарын зарлагын ДНБ-тэй харьцуулсан харьцаа буурсан шалтгаан нь тухайн хугацаанд ДНБ нэрлэсэн үнээр 16.7 их наядаас 54.9 их наяд болж 3.3 дахин өссөн байна.


Салбарын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийн ерөнхий хандлага сөрөг, маш бага бууралттай /бууралтын коэффициент -0.0002/байна.

² Эх үүсвэр: Сангийн яам 2012-2022

Салбарын төсвийн зарлага улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь 2012 онд 1.1% байсан бол 2022 онд 0.3% болж 0.8 пунктээр буурсан байна. Энэ нь хэдийгээр улсын нэгдсэн төсвийн зарлага нэмэгдсэн ч тухайн салбарын төсөв өсөөгүйтэй холбоотой байна. Тухайн хугацаанд улсын нэгдсэн төсвийн зардал 6.0 их наядаас 18.2 их наяд болж 3 дахин огцом өссөн байна.

Улсын төсвийн нэгдсэн зарлагад эзлэх хувийн ерөнхий хандлага сөрөг, маш бага бууралттай /бууралтын коэффициент -0.0006/байна.

Зураг 11. Салбарын төсвийн зарлагын ДНБ ба улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь /тэрбум төг./



4.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БА ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ҮР ДҮН

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны Биеийн тамир, спортын салбарт хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт болон Монгол улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын 2024 оны төсвийн хавсралт 1 дээрх хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг харьцуулж бодлогын баримт бичиг болон төсвийн уялдааг харууллаа.

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Биеийн тамир, спортын салбарын 1 хүрэх үр дүн болон 1 шалгуур үзүүлэлт байна.

Хүснэгт 5. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	2021	2022	2023	2024
Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.						
Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар)	Хувь	53	54.5	56	57.5	59
Шалгуур үзүүлэлтийн тайлбар: Сорилд хамрагдсан А, В, С үнэлгээтэй хүний тоог сорилд хамрагдсан хүний тоонд харьцуулна.						

Монгол улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын Биеийн тамир, спорт хөтөлбөр нь 2 хүрэх үр дүнтэй ба нийт 4 шалгуур үзүүлэлт хангана гэж төсвийн хавсралт 1 дээр тусгаж оруулсан байна.

Хүснэгт 6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

71701 Биеийн тамир, спорт						
Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	2024 оны зорилтот түвшин	
Идэвхтэй амьдралын хэвшилтэй хүний тоог нэмэгдүүлнэ.	6-64 насны бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан хүмүүст А, В, С үнэлгээ авсан хүний эзлэх хувь /хүйсээр/	хувь	2022	53	59	
Тив, дэлхийн спортын амжилтыг нэмэгдүүлнэ.	Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн /олимпын наадам/- ээс авах медаль	тоо	2022	14	16	
	Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн /олимпын наадам/-д оролцох эрх авах тамирчид	тоо	2021	56	58	
	Тивийн аварга шалгаруулах тэмцээн /тивийн наадам/-ээс авах медаль	тоо	2022	43	45	

Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ гэсэн хүрэх үр дүн ба Сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт (насны ангиллаар) гэсэн шалгуур үзүүлэлт тусгасан байгаа нь ТЕЗ-ийн төсвийн хавсралт 1 дээр тусгасан хөтөлбөрийн үр дүнтэй агуулгын хувьд ижил байгаа ба 1 шалгуур

үзүүлэлт тусгасан байгаа нь харагдаж байна. Хүрэх түвшний хувьд 2022 онд төдийлөн зорилгодоо хүрээгүй байгаа ч 2024 онд хүрэх түвшин нь адилхан 59 хувьд хүргэхээр тусгасан байна.

Биеийн тамир, спортын үйлчилгээ нь хүн амын төвлөрлийг дагаж зохион байгуулалт хийж байх шаардлагатай бөгөөд хот, дүүрэг, аймгийн төвийн сумдад орон нутгийн Биеийн тамир, спортын байгууллагууд үйлчилгээ үзүүлэх боломжтой байгаа.

Харин алслагдсан сумдад орон нутгийн Биеийн тамир, спортын байгууллагууд тогтмол үйлчилгээ үзүүлэх боломж хомс тул алслагдсан сумдад биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх орон тооны арга зүйч ажиллах шаардлагатай юм.

Арга зүйч нь сумын иргэдээс Бие бялдрын түвшин тогтоох сорил авах, сорилын үр дүнд тулгуурласан үйлчилгээ үзүүлж хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний хомсдолоос шалтгаалсан халдварт бус өвчлөлийн эрсдэлийг бууруулах, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээлдэхгүй иргэдийг татан оролцуулах арга хэмжээг зохион байгуулах ажлыг гүйцэтгэнэ.

Тухайн салбарт 2022 оны байдлаар нийт 61 арга зүйч тухайн салбарт ажиллаж байна. Аймаг, нийслэл тус бүрээр авч үзэхэд спортын нэг ажилтанд ногдох хүн ам адилгүй байна. Нэг ажилтанд дунджаар 8458 хүн ногдож байгаа бол Хөвсгөл аймагт 15,190, Архангай аймагт 13,382, Завхан аймагт 12,044, нийслэл хотод 11,812 хүн ам ногдож байна. Харин Говьсүмбэр аймагт нэг спортын ажилтанд 2009, Увс аймагт 3,361, Сүхбаатар аймагт 4,329 хүн ам ногдож байна. Энэ нь тухайн байгууллагын боловсон хүчин тухайн орон нутгийн хүн амтай уялдахгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 7. Биеийн тамир, спортын байгууллагын ажиллагчдын мэдээ

№	Аймаг	Нийт орон тоо	Мэргэжилтэн	Дасгалжуулагч	Биеийн тамирын арга зүйч	Спортын нэг ажилтанд ногдох хүн ам
1	Архангай	25	2	2	3	13,382
2	Баян-Өлгий	27	2	5	5	9,484
3	Баянхонгор	32	2	7	1	8,872
4	Булган	27	0	3	4	7,694
5	Говь-Алтай	20	1	2	5	7,182
6	Дорноговь	39	2	11	0	5,484
7	Дорнод	21	0	7	1	10,446
8	Дундговь	15	2	3	1	7,776
9	Завхан	18	1	4	1	12,044
10	Өвөрхангай	35	8	2	1	10,486
11	Өмнөговь	25	3	11	1	4,521
12	Сүхбаатар	31	2	11	1	4,329
13	Сэлэнгэ	56	1	7	7	7,207
14	Төв	25	1	9	3	7,135
15	Увс	39	10	0	15	3,361
16	Ховд	24	0	8	1	10,122
17	Хөвсгөл	23	0	6	3	15,190
18	Хэнтий	31	3	11	0	5,640

19	Дархан-уул	23	0	10	1	9,804
32	Орхон	29	9	0	0	12,102
33	Говь сүмбэр	24	8	0	0	2,009
29	Нийслэлийн БТСГ	11	7	0	0	11,812
20	Багануур	18	6	0	0	
21	Багахангай	20	10	0	0	
22	Баянгол	24	9	3	0	
23	Баянзүрх	13	4	0	4	
24	Налайх	10	6	0	0	
25	Чингэлтэй	47	6	12	2	
26	Сонгинохайрхан	25	6	5	0	
27	Сүхбаатар	13	9	0	1	
28	Хан-Уул	22	8	0	0	
30	БТСУХ	50	28	0	0	
31	Спортын АУ-ы төв	19	4	0	0	
	Нийт	861	160	139	61	
	Дундаж					8,458

Тайлант хугацааны гүйцэтгэлээр биеийн тамир, спортын салбарын нэг хүн амд ногдох нийт зардал дунджаар 14.6 мянган төгрөг, нэг хүн амд ногдох урсгал зардал 6.9 мянган төгрөг байна.

Хүснэгт 8. Нэг хүн амд ногдох зардал /мян.төг/


Он	Нийт гүйцэтгэл	Урсгал зардлын гүйцэтгэл	Хүн амын тоо	Нэг хүн амд ногдох нийт зардал	Нэг хүн амд ногдох урсгал зардал
2012	63,791,166.9	18,965,121.5	2,760,604.0	23.1	6.9
2013	48,735,342.2	20,549,364.3	2,823,137.0	17.3	7.3
2014	40,116,206.1	20,878,660.7	2,937,927.0	13.7	7.1
2015	34,806,397.6	17,157,847.6	2,990,242.0	11.6	5.7
2016	36,974,689.5	21,534,811.0	3,063,568.0	12.1	7.0
2017	26,332,512.5	20,693,952.5	3,131,750.0	8.4	6.6
2018	37,691,653.7	24,670,799.3	3,186,347.0	11.8	7.7
2019	35,662,439.3	12,372,963.7	3,197,020.0	11.2	3.9
2020	50,635,151.0	26,685,693.1	3,253,283.0	15.6	8.2
2021	57,106,189.8	24,985,237.0	3,312,275.0	17.2	7.5
2022	61,809,879.9	27,117,738.9	3,368,632.0	18.3	8.1

5. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ТӨСВИЙН НАЙДВАРТАЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Биеийн тамир, спортын салбарын төсвийн зарлагын гүйцэтгэл 2012 онд 63.8 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 61.8 тэрбум төгрөг болж 3.1 хувиар буурсан байна. 2012-2022 оны хугацаанд авч үзвэл 2017 онд хамгийн бага гүйцэтгэл буюу 26.3 тэрбумын гүйцэтгэл гарсан бөгөөд энэ нь 2012 онтой харьцуулахад 58.7 хувиар бага төсвийн гүйцэтгэл гарсан байна.

Салбарын батлагдсан төсөв ба төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг харьцуулан зураг 10-д харуулав. 2012-2022 оны 11 жилийн хугацаанд салбарын батлагдсан төсвийг тухайн жилд нь бүрэн зарцуулдаггүй бөгөөд төсвөөс дутуу зарцуулагдсан хэсгийг доорх зурагт цэнхрээр будаж дүрслэв.

Зураг 12. Салбарын батлагдсан төсөв, гүйцэтгэл /тэрбум.төг/



Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2012-2022

Төсвийг зөв төлөвлөж, батлагдсан төсвийг зөв удирдан гүйцэд зарцуулан төсвийн найдвартай, нийцтэй байдлыг хангах нь татвар төлөгчдийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж байгааг илтгэх шалгуур болдог.

“Төсвийн найдвартай байдал” нь төсөв бодитой бөгөөд зориулалтын дагуу зарцуулагдсан эсэхийг илэрхийлдэг. Төсвийн найдвартай байдлыг үнэлэхэд төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл (төсөв, санхүүгийн удирдлагын системийн шууд үр дүн)-ийг анх батлагдсан төсөвтэй харьцуулж гарсан зөрүүг тооцоолно.

Салбарын төсвийн найдвартай байдлыг үнэлэхдээ нийт зарлагын гүйцэтгэл, зарлагын гүйцэтгэлийг зардлын ангиллаар, орлогын гүйцэтгэлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.

5.1. НИЙТ ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Биеийн тамир, спортын салбарын зарлагын гүйцэтгэл, түүний өөрчлөлтийн хувийг 2012-2022 оноор гаргаж зураг 11-т харуулав.

Энэ хугацаанд салбарын зарлагын гүйцэтгэл нь батлагдсан төсвийн хэлбэлзлээс шалтгаалан мөн хэлбэлзэлтэй /SD=12.3/ байна. Зарлагын гүйцэтгэл 2012-2017 онд дунджаар 58.7% буурсан бол 2018-2022 онд 39%-иар нэмэгдсэн байна. Өөрчлөлтийн SD=25% байгаа нь их хэлбэлзэлтэй байна:

Зураг 13. Төсвийн зарлагын гүйцэтгэл, жилийн өсөлтийн хувь /тэрбум төг./



Өнгөрсөн 11 жилийн хугацаанд батлагдсан төсвийн гүйцэтгэлийн хувь 2019 онд хамгийн бага буюу 63.2% байсан бол 2022 онд гүйцэтгэлийн хувь хамгийн өндөр буюу 97.7% байжээ. Салбарын төсвийн гүйцэтгэл 2019-2020 онд муу байсан нь дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахлын үеийн хөл хорионы нөхцөл байдалтай холбоотой байна.

Биеийн тамир, спортын салбарын 2012-2022 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийг батлагдсан нийт төсөвтэй хүснэгт 9-д харуулав.

Хүснэгт 9. Нийт зарлагын батлагдсан төсөв ба гүйцэтгэл /сая.төг/

Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийг төсөвт харьцуулсан хувь
2012	68,787.3	63,791.2	-4,996.1	92.7%
2013	63,952.8	48,735.3	-15,217.5	76.2%
2014	46,845.2	40,116.2	-6,729.0	85.6%
2015	39,375.8	34,806.4	-4,569.4	88.4%
2016	40,229.4	36,974.7	-3,254.7	91.9%
2017	28,194.0	26,332.5	-1,861.5	93.4%
2018	41,032.1	37,691.7	-3,340.4	91.9%
2019	56,448.8	35,662.4	-20,786.3	63.2%
2020	59,350.9	50,635.2	-8,715.7	85.3%
2021	58,871.4	57,106.2	-1,765.2	97.0%
2022	63,291.2	61,809.9	-1,481.3	97.7%

Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2012-2022

Салбарын нийт зарлагын гүйцэтгэл 2020 онд 85.3%, 2021 онд 97.0%, 2022 онд 97.7% тус тус байсан буюу сүүлийн 3 жилээс 2 жилд нь буюу 2021, 2022 онд гүйцэтгэл 95%-аас дээш гарсан байна.

5.2. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ, ЗАРДЛЫН АНГИЛЛААР

Төсвийн зарлагын гүйцэтгэлийн явцад төсвийн зардлын ангилал хооронд дахин хуваарилалт хийсэн нь батлагдсан төсвийн бүрэлдэхүүнд нөлөөлсөн байдлыг тодорхойлох зорилгоор нийт зарлагын баталсан төсөв ба гүйцэтгэлийн зөрүүг байгууллагын төрөл, эдийн засгийн засгийн ангиллаар 2020-2022 оноор тооцож дараах хүснэгт 10-12-д харуулав.

Хүснэгт 10. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2020 он

Байгууллага	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Зөрүү абсолют утга	Хувиар
Биеийн тамир, спортын улсын хороо	28,496.7	26,685.7	-1,811.0	1,811.0	6.4%
Спортын салбарын ХО, ИЗ /2016-08-14/	30,854.2	23,949.5	-6,904.7	6,904.7	22.4%
НИЙТ	59,350.9	50,635.2	-8,715.7	8,715.7	14.7%
Зөрүүний жилийн дундаж хувь					14.4%
Нийт зөрүүний нийт зарлагад эзлэх хувь					17.2%

Хүснэгт 11. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2021 он

Байгууллага	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Зөрүү абсолют утга	Хувиар
Биеийн тамир, спортын улсын хороо	14,902.3	14,878.5	-23.8	23.8	0.2%
Спортын салбарын ХО, ИЗ /2016-08-14/	32,830.4	32,121.0	-709.4	709.4	2.2%
Спортыг дэмжих сан	520.0	0.0	-520.0	520.0	100.0%
Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар	7,188.4	6,897.6	-290.9	290.9	4.0%
БТСГ - УБ, Баянгол дүүргийн БТСГ	241.2	218.6	-22.6	22.6	9.4%
БТСГ - УБ, Баянзүрх дүүргийн БТСГ	175.5	156.1	-19.4	19.4	11.0%
БТСГ - УБ, Сонгино хайрхан дүүргийн БТСГ	391.9	355.9	-36.0	36.0	9.2%
БТСГ - УБ, Чингэлтэй дүүргийн БТСГ	484.3	464.4	-19.8	19.8	4.1%
БТСГ - УБ, Багануур дүүргийн БТСГ	258.5	237.9	-20.6	20.6	8.0%
БТСГ - УБ, Сүхбаатар дүүргийн БТСГ	131.0	112.6	-18.4	18.4	14.0%
БТСГ - УБ, Хан-Уул дүүргийн БТСГ	399.4	357.8	-41.6	41.6	10.4%
БТСГ - УБ, Багахангай дүүргийн БТСГ	201.2	183.6	-17.6	17.6	8.8%
БТСГ - УБ, Налайх дүүргийн БТСГ	179.8	161.8	-18.0	18.0	10.0%
Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	967.4	960.3	-7.0	7.0	0.7%
НИЙТ	58,871.4	57,106.2	-1,765.2	1,765.2	3.0%
Зөрүүний жилийн дундаж хувь					13.7%
Нийт зөрүүний нийт зарлагад эзлэх хувь					3.1%

Хүснэгт 12. Зарлагын төсвийн гүйцэтгэл, байгууллагаар, 2022 он

Байгууллага	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Зөрүү абсолют утга	Хувиар
Биеийн тамир, спортын улсын хороо	14,954.0	14,210.3	-743.7	743.7	5.0%
Спортын салбарын ХО, ИЗ /2016-08-14/	35,162.9	34,692.1	-470.8	470.8	1.3%

Аймаг, нийслэлийн БТСГ	8,862.3	8,690.5	-171.8	171.8	1.9%
БТСГ - УБ, Баянгол дүүргийн БТСГ	386.2	367.1	-19.1	19.1	5.0%
БТСГ - УБ, Баянзүрх дүүргийн БТСГ	419.5	408.0	-11.5	11.5	2.7%
БТСГ - УБ, Сонгино хайрхан дүүргийн БТСГ	471.4	470.8	-0.6	0.6	0.1%
БТСГ - УБ, Чингэлтэй дүүргийн БТСГ	421.5	420.3	-1.2	1.2	0.3%
БТСГ - УБ, Багануур дүүргийн БТСГ	322.0	309.1	-13.0	13.0	4.0%
БТСГ - УБ, Сүхбаатар дүүргийн БТСГ	301.6	291.2	-10.4	10.4	3.5%
БТСГ - УБ, Хан-Уул дүүргийн БТСГ	402.9	385.9	-17.0	17.0	4.2%
БТСГ - УБ, Багахангай дүүргийн БТСГ	290.0	274.2	-15.8	15.8	5.4%
БТСГ - УБ, Налайх дүүргийн БТСГ	234.1	233.8	-0.2	0.2	0.1%
Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв	1,062.8	1,056.6	-6.2	6.2	0.6%
НИЙТ	63,291.2	61,809.9	-1,481.3	1,481.3	2.3%
Зөрүүний жилийн дундаж хувь					2.6%
Нийт зөрүүний нийт зарлагад эзлэх хувь					2.4%

Дээрх хүснэгтүүдээс харахад байгууллагаар баталсан төсвийн гүйцэтгэлийн зөрүүний дундаж хувь байгууллагын хувьд 2020 онд 14.4%, 2021 онд 13.7%, 2022 онд 2.6% тус тус байжээ. Түүнчлэн батлагдсан төсөв ба гүйцэтгэлийн зөрүүний нийт зарлагад эзлэх хувь 2020 онд 17.2%, 2021 онд 3.1%, 2022 онд 2.4% тус тус байна. 2020 онд Ковидын нөхцөл байдлын улмаас хөл хорио тогтоосонтой холбоотойгоор батлагдсан төсвөө гүйцэд зарцуулж чадаагүй байна. Харин 2021, 2022 онд байгууллагуудын төсвийн гүйцэтгэл сайн байна.

Салбарын батлагдсан төсөв ба зарлагын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар хүснэгт 13-д оруулав.

Хүснэгт 13. Салбарын төсөв ба гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар (сая төгрөгөөр)

Зардлын ЭЗ-ийн ангилал	2020		2021		2022	
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,350.9	50,635.2	58,871.4	57,106.2	63,291.2	61,809.9
21 УРСГАЛ ЗАРДАЛ	28,496.7	26,685.7	26,041.0	24,985.2	28,128.3	27,117.7
210 БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,021.3	14,255.9	23,507.3	22,456.7	24,327.1	23,942.6
2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,012.5	2,855.1	8,036.9	7,935.9	8,329.3	8,160.0
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	383.5	351.5	1,087.1	1,038.3	1,036.7	1,017.6
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225.9	157.7	174.0	174.0	224.9	183.4
2104 Хангамж, бараа материалын зардал	38.3	37.4	305.9	299.5	368.2	350.9
2105 Нормативт зардал	10.6	10.6	408.9	407.9	514.1	511.8
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	1,627.4	1,393.8	322.1	321.2	111.2	111.0
2107 Томилолт, зочны зардал	1.6	1.6	26.1	24.7	65.0	51.3
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,930.9	8,796.7	11,570.0	11,464.2	10,072.4	10,023.6
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	790.6	651.4	1,576.3	791.1	3,605.4	3,533.1
212 ТАТААС	9,600.0	9,598.9	0.0	0.0	0.0	0.0
2121 Терийн өмчит байгууллагад олгох татаас	9,600.0	9,598.9	0.0	0.0	0.0	0.0
213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,875.3	2,830.8	2,533.7	2,528.5	3,801.2	3,175.1
2131 Засгийн газрын урсгал шилжүүлэг	92.8	60.3	68.7	68.5	70.0	70.0

2132 Бусад урсгал шилжүүлэг	2,782.5	2,770.6	2,465.0	2,460.0	3,731.2	3,105.1
22 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,854.2	23,949.5	32,830.4	32,121.0	35,162.9	34,692.1
3 ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,350.9	50,635.2	58,871.4	57,117.1	63,291.2	62,251.1
31 Улсын төсвөөс санхүүжих	59,350.9	50,635.2	58,416.0	56,968.4	63,291.2	62,185.7
35 Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.0	0.0	455.4	148.7	0.0	65.4

Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020-2022.

Эдийн засгийн ангиллаар баталсан төсөв ба гүйцэтгэлийн зөрүүний үзүүлэлтийг тооцохдоо төсвийн эдийн засгийн ангиллыг дараах байдлаар бүлэглэж авч үзлээ. /хүснэгт 14-16/

Хүснэгт 14. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2020 он

Зардлын эдийн засгийн ангиллын бүлэг	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Зөрүү абсолют утга	Хувиар
НИЙТ	59,350.9	50,635.2	-	8,715.7	14.7%
2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,350.9	50,635.2	-8,715.7	8,715.7	14.7%
21 УРСГАЛ ЗАРДАЛ	28,496.7	26,685.7	-1,811.0	1,811.0	6.4%
210 БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,021.3	14,255.9	-	1,765.4	11.0%
2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,012.5	2,855.1	-157.4	157.4	5.2%
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	383.5	351.5	-32.0	32.0	8.4%
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	225.9	157.7	-68.2	68.2	30.2%
2104 Хангамж, бараа материалын зардал	38.3	37.4	-0.9	0.9	2.2%
2105 Норматив зардал	10.6	10.6	0.0	0.0	0.0%
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	1,627.4	1,393.8	-233.6	233.6	14.4%
2107 Томилт, зочны зардал	1.6	1.6	0.0	0.0	0.0%
2108 Бусдаар гийцэтгэлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,930.9	8,796.7	-1,134.1	1,134.1	11.4%
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	790.6	651.4	-139.2	139.2	17.6%
212 ТАТААС	9,600.0	9,598.9	-1.1	1.1	0.0%
2121 Төрийн өмчит байгууллагад олгох татаас	9,600.0	9,598.9	-1.1	1.1	0.0%
213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,875.3	2,830.8	-44.5	44.5	1.5%
2131 Засгийн газрын урсгал шилжүүлэг	92.8	60.3	-32.5	32.5	35.0%
2132 Бусад урсгал шилжүүлэг	2,782.5	2,770.6	-12.0	12.0	0.4%
22 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,854.2	23,949.5	-	6,904.7	22.4%
3 ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,350.9	50,635.2	-8,715.7	8,715.7	14.7%
31 Улсын төсвөөс санхүүжих	59,350.9	50,635.2	-8,715.7	8,715.7	14.7%

Хүснэгт 15. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2021 он

Зардлын эдийн засгийн ангиллын бүлэг	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Зөрүү абсолют утга	Хувиар
НИЙТ	58,871.4	57,106.2	-1,765.2	1,765.2	3.0%
2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,871.4	57,106.2	-1,765.2	1,765.2	3.0%
21 УРСГАЛ ЗАРДАЛ	26,041.0	24,985.2	-1,055.8	1,055.8	4.1%
210 БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,507.3	22,456.7	-1,050.6	1,050.6	4.5%
2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	8,036.9	7,935.9	-101.0	101.0	1.3%
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,087.1	1,038.3	-48.9	48.9	4.5%
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	174.0	174.0	0.0	0.0	0.0%
2104 Хангамж, бараа материалын зардал	305.9	299.5	-6.4	6.4	2.1%
2105 Норматив зардал	408.9	407.9	-1.0	1.0	0.2%
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	322.1	321.2	-0.9	0.9	0.3%
2107 Томилт, зочны зардал	26.1	24.7	-1.4	1.4	5.4%

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,570.0	11,464.2	-105.9	105.9	0.9%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,576.3	791.1	-785.2	785.2	49.8%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,533.7	2,528.5	-5.2	5.2	0.2%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	68.7	68.5	-0.2	0.2	0.3%
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,465.0	2,460.0	-5.0	5.0	0.2%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,830.4	32,121.0	-709.4	709.4	2.2%
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,871.4	57,117.1	-1,754.3	1,754.3	3.0%
31	Улсын төсвөөс санхүүжих	58,416.0	56,968.4	-1,447.6	1,447.6	2.5%
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	455.4	148.7	-306.7	306.7	67.4%

Хүснэгт 16. Зарлагын төсвийн гүйцэтгэл, ЭЗ-ийн ангиллаар, 2022 он

Зардлын эдийн засгийн ангиллын бүлэг	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Зөрүү абсолют утга	Хувиар
НИЙТ	63,291.2	61,809.9	-1,481.3	1,481.3	2.3%
2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,291.2	61,809.9	-1,481.3	1,481.3	2.3%
21 УРСГАЛ ЗАРДАЛ	28,128.3	27,117.7	-1,010.5	1,010.5	3.6%
210 БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,327.1	23,942.6	-384.5	384.5	1.6%
2101 Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	8,329.3	8,160.0	-169.3	169.3	2.0%
2102 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,036.7	1,017.6	-19.1	19.1	1.8%
2103 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224.9	183.4	-41.5	41.5	18.5%
2104 Хангамж, бараа материалын зардал	368.2	350.9	-17.3	17.3	4.7%
2105 Нормативт зардал	514.1	511.8	-2.3	2.3	0.4%
2106 Эд хогшил, урсгал засварын зардал	111.2	111.0	-0.1	0.1	0.1%
2107 Томилолт, зочны зардал	65.0	51.3	-13.7	13.7	21.1%
2108 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,072.4	10,023.6	-48.7	48.7	0.5%
2109 Бараа үйлчилгээний бусад зардал	3,605.4	3,533.1	-72.4	72.4	2.0%
213 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,801.2	3,175.1	-626.1	626.1	16.5%
2131 Засгийн газрын урсгал шилжүүлэг	70.0	70.0	0.0	0.0	0.0%
2132 Бусад урсгал шилжүүлэг	3,731.2	3,105.1	-626.1	626.1	16.8%
22 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,162.9	34,692.1	-470.8	470.8	1.3%
3 ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,291.2	62,251.1	-1,040.1	1,040.1	1.6%
31 Улсын төсвөөс санхүүжих	63,291.2	62,185.7	-1,105.5	1,105.5	1.7%

Салбарын баталсан төсөв ба гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар 2020-2022 оноор гаргаж үзэхэд, мөн Ковидын нөлөөллөөр 2020 онд эдийн засгийн ангиллаар баталсан зардлын төсвийн гүйцэтгэл зөрүү ихтэй байна. Эдийн засгийн ангиллаар баталсан төсөв ба зарлагын гүйцэтгэлийн зөрүү 2021 онд /3%/ , 2022 онд /2.3%/ жилдээ 5%-аас бага буюу сайн үзүүлэлттэй байсан байна.

5.3. ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Салбарын үйл ажиллагааг дэмжих, үзүүлж буй үйлчилгээг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор төсвийн байгууллагуудын төсөвт орлогын төлөвлөгөө батлахгүй байхаар тухайн жилийн Төсвийн тухай хуулиар зохицуулсан. Ингэснээр төсвийн байгууллагууд орлого олсон тохиолдолд байгууллагын үйл ажиллагааны нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан тухай бүрд нь зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанд зарцуулах эрхтэй болсон.

Сангийн сайдын 2019 оны 74 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэл тусгах, хяналт тавих журам”-аар

төсөвт байгууллага өөрийн орлогыг зарцуулах зардлын төрлийг зохицуулсан байна. Уг журмын дагуу төсвийн байгууллага шинээр болон нэмэлтээр орлого олсон тохиолдолд байгууллагын өр төлбөрөө барагдуулах, ажлын үр дүнг нь харгалзан ажилтнуудад урамшуулал олгох, хэрэв орлого үлдвэл ажилтнуудын нийгмийн хамгааллын зардалд зарцуулж болохоор журамласан байдаг.

Хүснэгт 17. Нийт орлогын гүйцэтгэл, мян төгрөгөөр

Байгууллага	Үзүүлэлт	Тайлант он		
		2020	2021	2022
Биеийн тамир, спортын улсын хороо	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого	21,415.3	59,504.5	87,500.0
Аймгийн БТСГ	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого	0.0	0.0	464,824.8
Нийт		21,415.3	59,504.5	552,324.8

Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020-2022

Цар тахлын үеийн хөл хорио үргэлжилсэн 2020, 2021 онд төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлого бага байсан бол 2022 онд өсөж, 552.3 сая төгрөгийн орлого олсон байна. Салбарын төсвийн байгууллагуудад орлогын төсөв баталдаггүй учраас орлогын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хэмжих боломжгүй байна.

Салбарын төсвийн найдвартай байдлыг үнэлэх зорилгоор салбарын нийт төсвийн зарлагын гүйцэтгэл, байгууллагаар болон эдийн засгийн ангиллаар баталсан зардлын төсөв ба гүйцэтгэл, орлогын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг дээрх хүснэгтүүдэд тооцож үзлээ. Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг анх баталсан төсөвтэй нь харьцуулахад сүүлийн 3 жилийн хугацаанд төсвийн найдвартай байдал “сайн” байна. Учир нь байгууллагаар болон эдийн засгийн ангиллаар баталсан салбарын төсвийн дахин хуваарилалт хэвийн түвшинд байгааг илэрхийлж байна. Салбарын батлагдсан төсөв ба гүйцэтгэлийг байгууллагаар, эдийн засгийн ангиллаар үзэхэд хөрөнгө оруулалтын зардлын дутуу гүйцэтгэл нь төсвийн гүйцэтгэлд хамгийн их нөлөө үзүүлж байна.

6. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХӨТӨЛБӨР, ЗОРИУЛАЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын хувьд хөтөлбөрт суурилсан төсөвлөлтөд 2013 оноос шилжсэн. Төсвийг хөтөлбөрөөр төлөвлөх нь төсвийн зарлагыг зорилго, үр дүнд чиглүүлэн төлөвлөх, зарцуулалтад хяналт тавих зорилготой юм. Монгол Улсын хувьд ЭЗХАХБ-ууд болон НҮБ-ын Статистикийн хорооноос гаргасан Засгийн газрын чиг үүргийн ангилал (COFOG)³-д үндэслэсэн төсвийн хөтөлбөрийн ангиллыг Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлан мөрдөж байна. Хөтөлбөр бол гадагшаа чиглэсэн үйлчилгээнүүдийн багц буюу гарц эсхүл нийтлэг үр дагавар бүхий төлбөр шилжүүлгүүд юм. (Robinson, 2013) Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг хэлнэ гэж заасан байна.

Төсвийн хөрөнгийг зарцуулснаар бий болгох бүтээгдэхүүн, үйлчилгээ буюу гарцуудын нийлбэрээр хөтөлбөрийг тодорхойлох нь илүү үр дүнтэй юм. Тухайн хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа/гарц, үйлчилгээний төрлүүдийг тодорхойлсноор тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлэн шаардагдах зардлыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой юм.

Салбарын төсвийн зарлага нь 2020-2022 онд биеийн тамир, спорт хөтөлбөр, ангилагдаагүй бусад хөтөлбөр гэсэн 2 хөтөлбөрөөр зарцуулагдсан. Ангилагдаагүй бусад хөтөлбөрт хөрөнгө оруулалтын зардлын төсвийг баталдаг.

COFOG-д (European Union, 2019) тусгасан салбарын үзүүлж буй үйлчилгээний зарлагын хөтөлбөрийн ангилал болон СЯ-ны ашиглаж буй зарлагын хөтөлбөрийн ангиллыг харьцуулан дараах хүснэгт 18-д харуулав.

Хүснэгт 18. Хөтөлбөрийн ангиллын харьцуулалт

Код	COFOG ангилал	Код	СЯ-ны Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал
708	Амралт, соёл урлаг, шашин	71700	Соёл урлаг, спорт, аялал жуулчлал
7081	Амралт ба спортын үйлчилгээ	71701	Биеийн тамир спорт
7082	Соёл урлагийн үйлчилгээ	71702	Соёл урлаг
7083	Радио телевиз, хэвлэлийн үйлчилгээ	71703	Аялал жуулчлал
7084	Шашны болон бусад хэвлэлийн үйлчилгээ	71704	Соёл урлаг, спорт, аялал жуулчлалын бодлого, удирдлага
7085	Амралт, соёл урлаг, шашны судалгаа шинжилгээ	71705	Соёл урлаг, спорт, аялал жуулчлалын судалгаа шинжилгээ
7086	Амралт, соёл урлаг, шашны бусад		

Сангийн сайдын тушаалаар баталсан биеийн тамир, спортын салбарын төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал нь олон улсын COFOG хөтөлбөрийн ангилалтай ойролцоо байна.

³OECD (2023), *Government at a Glance 2023*. OECD Publishing, Paris. <https://doi.org/10.1787/3d5c5d31-en>

Салбарын төсвийн зарлагын ихэнх хувь нь биеийн тамир, спорт хөтөлбөрөөр дамжуулан зарцуулагдаж байна. Салбарын хөрөнгийн зардлын төсвийг 2020, 2021 онд биеийн тамир, спорт хөтөлбөрөөс салгаж “ангилагдаагүй бусад” гэсэн хөтөлбөрт тусгаж байжээ. Харин 2022 оны төсвийн жилд салбарын хөрөнгийн зардлын төсвийг биеийн тамир, спорт хөтөлбөрт оруулан баталсан байна. Тухайлбал, 2022 онд биеийн тамир, спорт хөтөлбөрийн зарлага 63.8 тэрбум төгрөгөөр батлагдсан байна. 2022 онд биеийн тамир, спорт хөтөлбөрийн зарлагын гүйцэтгэл 61.8 тэрбум төгрөг байна. /Хүснэгт 19/

Хүснэгт 19. Салбарын зарлагын гүйцэтгэл, хөтөлбөрөөр, сая төгрөгөөр

Хөтөлбөрийн нэр, код	2020			2021			2022		
	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэл-ийн хувь	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэл-ийн хувь	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэл-ийн хувь
Биеийн тамир спорт 71701	28,496.7	50,635.2	177.7%	26,041.0	57,106.2	219.3%	63,291.2	61,809.9	97.7%
Ангилагдаагүй бусад 72301	30,854.2	0.0	0.0%	32,830.4	0.0	0.0%	0.0	0.0	
НИЙТ	59,350.9	50,635.2	85.3%	58,871.4	57,106.2	97.0%	63,291.2	61,809.9	97.7%

Биеийн тамир, спорт хөтөлбөрт салбарын үйл ажиллагааны төсөв бүхэлдээ батлагддаг бөгөөд 2020-2022 онд салбарын урсгал зардлын хөтөлбөр нь зардлын 9 зориулалт, 19 арга хэмжээнд ангилагдаж байна.

Биеийн тамир, спорт хөтөлбөрт салбарын үйл ажиллагааны төсөв бүхэлдээ батлагддаг бөгөөд 2020-2022 онд салбарын урсгал зардлын хөтөлбөр нь зардлын 9 зориулалт, 19 арга хэмжээнд ангилагдаж байна. Хөтөлбөрүүдийн зардлын зориулалт, арга хэмжээний ангиллыг доорх хүснэгт 20-д үзүүлэв.

Хүснэгт 20. Салбарын төсвийн зарлагын хөтөлбөр, зардлын зориулалт, арга хэмжээний ангиллаар /сая. төг/

Хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ	2020 гүйцэтгэл	2021 гүйцэтгэл	2022 гүйцэтгэл
717010 Биеийн тамир спорт	50,635.2	57,106.2	61,809.9
801 Үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт	3,387.8	11,399.3	11,087.5
801010 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,843.4	9,369.1	10,906.8
801020 Туслах үйл ажиллагааны зардал	0.0	2,010.2	180.7
801030 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	544.3	20.0	0.0
802 Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт	240.8	262.8	323.1
802150 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	0.0	0.0	10.0
802190 Харуул, хамгаалалтын зардал	35.8	52.3	30.7
802260 Байр ашиглалтын ийлчилгээ	204.9	210.5	282.5
803 Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт	0.0	446.3	1,690.3
803050 Биеийн тамирын уралдаан, тэмцээн	0.0	446.3	1,690.3
805 Засгийн газрын дотоод болон гадаад шилжүүлгийн зориулалт	60.3	68.5	70.0
805090 Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	60.3	68.5	70.0
807 Нийгмийн халамжийн шилжүүлгийн зориулалт	0.0	10.0	168.2
807040 Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	0.0	10.0	168.2
808 Бусад шилжүүлгийн зориулалт	80.7	375.8	662.9
808020 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	80.7	375.8	662.9
809 Хөрөнгийн зардлын зориулалт	23,949.5	32,121.0	34,692.1


809180	Бусад	23,949.5	32,121.0	34,692.1
821	Биеийн тамир, спортын арга хэмжээ	13,317.3	12,422.4	13,115.7
821010	Улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих	8,944.6	9,411.6	7,650.0
821020	Олон улсын тэмцээн, уралдаанд оролцох	142.9	557.6	239.0
821030	Олон улсын бусад тэмцээн уралдааны шагнал	1,069.9	501.0	442.0
821040	Дотоодод тэмцээн уралдаан зохион байгуулах	458.6	119.7	1,278.4
821050	Олимп ДАШТ-с медаль авсан тамирчдын урамшуулал	1,620.0	1,573.2	1,832.0
821060	Нийтийн биеийн тамир	626.4	259.3	1,674.4
821090	Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих	455.0	0.0	0.0
833	Нэг удаагийн арга хэмжээ	9,598.9	0.0	0.0
833060	Олон улсын залуучуудын ногоон наадам	9,598.9	0.0	0.0

Эх үүсвэр. Сангийн яам. Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2022.

Биеийн тамир, спорт хөтөлбөрийн “үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт”-д харьяа төрийн өмчит байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны зардал тусгагддаг бол “биеийн тамир, спортын арга хэмжээ” зориулалтад биеийн тамир, спортын үйлчилгээг дэмжих зардлууд тусгагдаж байна. Энэ зориулалтад 7 төрлийн зориулалт, арга хэмжээ нь шинж чанар, хэмжээний хувьд харилцан адилгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээ, гарцын шинжтэй үйл ажиллагаануудын аль алиныг багтаасан ба сүүлийн 3 жилийн дунджаар нийт хөтөлбөрийн 23.1%-ийг эзэлж байна.

Хөтөлбөрийн арга хэмжээний зориулалтын зардлын гүйцэтгэлийг 2020, 2021, 2022 оноор дараах зураг 14-д харуулав.

Зураг 14. Биеийн тамир, спортын арга хэмжээ, зарлагын төрлөөр, сая төгрөгөөр



2020, 2021, 2022 оны төсвийн гүйцэтгэлээс харахад хамгийн их төсөв зарцуулсан арга хэмжээ нь улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардалд нийт 26.0 тэрбум төгрөг зарцуулсан байна. 2020 онд олон улсын залуучуудын ногоон наадам арга хэмжээнд 9.6 тэрбум төгрөгийг нэг удаа зарцуулсан байна. Мөн Олимп ДАШТ-с медаль авсан тамирчдын урамшуулалд нийт 5.0 тэрбум төгрөг, жилд дунджаар 1.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

7. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН УРСГАЛ БА ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ЧИГ ХАНДЛАГА, ХУВААРИЛАЛТ

Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын гүйцэтгэлийн хэмжээг 2012-2022 оноор гаргаж дараах хүснэгт 21-д харуулав.

Хүснэгт 21. Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын гүйцэтгэл, сая төгрөгөөр


	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Урсгал зардал	18,965.1	20,549.4	20,878.7	17,157.8	21,534.8	20,694.0	24,670.8	12,373.0	26,685.7	24,985.2	27,117.7
Хөрөнгийн зардал	44,826.0	28,186.0	19,237.5	17,648.6	15,439.9	5,638.6	13,020.9	23,289.5	23,949.5	32,121.0	34,692.1

Салбарын урсгал зардлын дундаж өсөлтийн хувь 2012-2017 онд тогтвортой буюу жилд 5.5 хувь байсан бол 2018-2019 онд урсгал зардал огцом буурч, өссөн байна. Урсгал зардал 2019 онд 49.8%-иар өмнөх оноос буурсан бол 2020 онд 115.7%-иар нэмэгдсэн байх бөгөөд өндөр хэлбэлзэлтэй /Std=42.7%/ байна. Урсгал зардлын сүүлийн жилүүдийн огцом хэлбэлзлийг оруулан тооцвол, 2012-2022 онд урсгал зардал жилд дунджаар 10.1 хувиар өссөн байна.

Харин хөрөнгө оруулалтын зардал 2017 онд 63.5%-иар өмнөх оноос буурсан бол 2018 онд 130.9%-иар нэмэгдсэн /Std=57.9%/ байна. Энэ нь төсвийн хэлбэлзэл маш өндөр байгааг харуулж байна.


Салбарын хөрөнгийн ба урсгал зардлын жилийн өсөлтийг доорх зураг 15-д дүрслэв.

Зураг 15. Урсгал ба хөрөнгийн зардлын жилийн өсөлт, хувиар



Салбарын 2012-2022 оны нийт төсвийн зарлагын гүйцэтгэлийн дунджаас харахад 54.2 хувь нь урсгал зардал, 45.8 хувь нь хөрөнгийн зардалд зарцуулагджээ. Энэ харьцаа 2012-2022 оны тайлант хугацаанд харьцангуй тогтвортой байгаа боловч урсгал зардал 2012 онд 29.7%-иас 2017 онд нийт зардлын 78.6% болж нэмэгдсэн бол 2019 онд 34.7 хувь болж буурсан нь эдгээр онд салбарын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.


Зураг 16. Төсвийн нийт зарлагын гүйцэтгэлд урсгал ба хөрөнгийн зардлын эзлэх хувь



Эх сурвалж: СЯ, Төсвийн гүйцэтгэлийн тайлан 2012-2022

Салбарын төсвийн урсгал ба хөрөнгийн зардлын гүйцэтгэлийн батлагдсан төсөвт эзлэх хувийг дараах зураг 15-д харууллаа. 2020-2022 оноос бусад онуудад хөрөнгийн зардлын гүйцэтгэл урсгал зардлын гүйцэтгэлээс доогуур хувьтай буюу жилд дунджаар 91.4% байжээ. Энэ нь хөрөнгийн зардалд батлагдсан төсвийн 8.6 орчим хувийг тухайн ондоо зарцуулж чадаагүй гэсэн үг юм.

Зураг 17. Салбарын урсгал ба хөрөнгийн зардлын төсвийн гүйцэтгэлийн хувь




Биеийн тамир, спортын салбарт 2012-2022 оны хугацаанд нийтдээ 566.4 тэрбум төгрөгийн улсын төсөв батлагдсанаас 493.7 тэрбум төгрөгийн зарлагыг санхүүжүүлж, зарлагын гүйцэтгэл 87.2% байжээ. Дутуу зарцуулагдсан төсвийн 12.8 хувиас урсгал зардлын төсөв 11.4% , 88.6 хувь нь хөрөнгийн зардлын төсөв байгаа нь хөрөнгийн зардлын төсвийн гүйцэтгэлийг сайжруулах шаардлагатайг мөн илэрхийлж байна.

7.1. САЛБАРЫН НИЙТ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХУВААРИЛАЛТ

Монгол Улсын биеийн тамир, спортын салбарын төрийн ба орон нутгийн үйлчилгээг аймаг, нийслэлийн БТСГ, БТСУХ, спортын анагаах ухаан эрдэм шинжилгээний төв гэсэн байгууллагуудаар дамжуулан зарцуулалт хийж байна.

Зураг 18. Нийт төсвийн зарлагын хуваарилалт, 2022 он



Зураг 19. Урсгал төсвийн зарлагын хуваарилалт, 2022 он




Урсгал зардлын хувьд БТСГ 43.7%, БТСУХ 52.4%-ийг эзэлж байна. Хэрэв нийт төсөвт хөрөнгийн зардлыг оруулан салбарын нийт төсвийн зарлагын хуваарилалтыг харвал нийт зарлагын 56.1 хувийг хөрөнгө оруулалтад, БТСГ 19.2%, БТСУХ 23.0%-ийг тус тус зарцуулсан байна. /Зураг 18, 19/

7.2. САЛБАРЫН УРСГАЛ ЗАРДЛЫН БҮТЭЦ

2012-2022 оны хугацаанд салбарын нийт урсгал зардлын дунджаар 63.7%-ийг бараа үйлчилгээний зардал, 33.1%-ийг урсгал шилжүүлэгт зарцуулсан. Бараа үйлчилгээний зардалд салбарын сайдад шууд харьяалагддаг төрийн өмчийн байгууллагын ажилтнуудын цалин хөлс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засвар, томилолтын зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж багтаж байна.


Зураг 20. Салбарын урсгал зардлын бүтэц /хувиар/



7.2.1. Салбарын урсгал зардалд цалин хөлсний зардлын эзлэх харьцаа

Салбарын 2012-2022 оны бараа үйлчилгээний зардалд цалин хөлс, НДШ-ийн зардлын эзлэх хувь дунджаар 31.7 хувь байна. /Зураг 21/ 2021, 2022 онд салбарын бараа, үйлчилгээний зардалд Цалин хөлс, НДШ-ийн зардлын эзлэх хувь нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2022 онд бараа үйлчилгээний зарлагын 38.0 хувь цалин хөлс, НДШ-ийн зардалд зарцуулагдсан байна.


Зураг 21. Салбарын бараа үйлчилгээний зардлын бүтэц, хувиар



Хэдийгээр урсгал зардалд цалин хөлсний зардал өндөр хувийг эзэлж байгаа боловч тус салбарт ажиллагчдын цалин хөлс нь улсын дундаж цалингаас доогуур байсан. Төрийн албан хаагчдын дотор биеийн тамир, спортын салбарын дараах хамгийн бага цалин хөлстэй төрийн үйлчилгээний албан хаагчид болдог.

Салбарын ажилтны үндсэн цалин 2023 оны эхний хагас жилийн байдлаар 766.5 мянган төгрөгтэй тэнцэж байсан.⁴ Энэ нь 2020 оны нийт цалин хөлстэй харьцуулахад 17.6 хувиар, 2020 оны үндсэн цалинтай харьцуулахад 10.6 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм.


Зураг 22. Бараа үйлчилгээний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулалт



Салбарын бараа үйлчилгээний зардлыг он тус бүрээр төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулж үзүүлээ. Бараа үйлчилгээний зардлыг цалин хөлс болон НДШ, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардал гэсэн 4 үндсэн бүлэгт хуваасан болно. Тайлант хугацаанд бараа үйлчилгээний зардлын бусдаар гүйцэтгүүлэх болон бусад зардал нь 48%-87%-ийг эзэлж байна. 2012 онд 48%, 2016 онд 83%, 2020 онд 76% болж нэмэгдсэн нь цаг хугацааны хувьд 4 жилийн давтамжаар нэмэгдсэнтэй холбоотой байна.

⁴ Засгийн газрын 2022 оны 107, 276, 487, 488 дугаар тогтоол <https://legalinfo.mn/mn/detail?lawid=16468129124141&showType=1>

Зураг 23. Харьяа байгууллагын ажилтны дундаж цалин хөлс, мянган төгрөгөөр



Эх үүсвэр: YCX, www.I2I2.mn

Тус салбарын ажилтны цалингийн бүтэц нь үндсэн цалин, Төрийн албаны тухай хуулийн 57.2.4-т заасны дагуух докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлснөөс тус тус бүрддэг байна. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн нэмэгдүүлэх арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлсэн. Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр зарим ажилтны албан тушаалын зэрэглэл болон цалингийн доод хэмжээг тогтоосноор салбарын ажилтны үндсэн цалин 2023 оны байдлаар 1,273.0 мянган төгрөгтэй тэнцэж, оны эхний хагас жилийн үеийн 766.5 мянган төгрөгөөс 66 орчим хувиар нэмэгдсэн байна.⁵ /Зураг 24/

Зураг 24. Биеийн тамир, спорт ба бусад салбарын цалин хөлс, мянган төгрөгөөр



⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759736441001&showType=1>

Салбарын үндсэн цалинг тооцохдоо тус салбарын мэргэжилтэй ажилтны /ТҮСБ-4/ үндсэн цалингаар тооцсон болно. 2023 оны 7 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлснээр салбарын ажилтнуудын үндсэн цалин боловсролын салбарынхтай адил болсон. Гэхдээ салбарын байгууллагын ажилтны нийт дундаж цалин боловсролын салбарынхнаас 27.3 хувиар, эрүүл мэндийн салбарынхнаас 24.1 хувиар тус тус доогуур, соёлын салбарынхнаас 13.6 хувиар бага байна.


Хүснэгт 22. Цалин хөлсний зөрүү (мянган төг.)

Салбар	Нийт цалин хөлсний зөрүү	Нийт цалин хөлсний зөрүү хувиар	Үндсэн цалингийн зөрүү	Үндсэн цалингийн зөрүү хувиар
Эрүүл мэнд	(337.80)	-24.1%	(64.0)	-5%
Боловсрол	(381.90)	-27.3%		
Соёл урлаг	(190.95)	-13.6%		

7.2.2. Салбарын урсгал зардалд тогтмол зардлын эзлэх харьцаа

Салбарын урсгал зардалд бусад зардлын эзлэх хувь өндөр байгаа бөгөөд цалин хөлс, НДШ-ийн зардал хувь дунджаар 24.1%, гадна байр ашиглалттай холбоотой түлш, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түрээсийн зардал 3.5%-ийг эзэлж байна. Нийт урсгал зардал болон бараа үйлчилгээний зардалд бусад зардлын эзлэх хувь 72.4%-ийг эзэлж байна.

Зураг 25. Салбарын зарим зардлын харьцаа, мянган төгрөгөөр



7.3. Салбарын хөрөнгийн зардлын чиг хандлага

Биеийн тамир, спортын салбарын хөрөнгийн зардлын дийлэнх нь шинээр барилга байгууламж барих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ юм. Биеийн тамир, спортын салбарт 2010-2023 онд хөрөнгө оруулалтын нийт 172 барилга байгууламж барих, их засвар, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний төсөв батлагдаж гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байна. Үүнээс 2022 оны эцсийн байдлаар 138 төсөл арга хэмжээг дуусгаснаас 100 барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулсан байна.

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг тухайн онд батлагдсан санхүүжих дүнтэй харьцуулахад 2010-2022 оны хугацаанд 85.4% байна. Хөрөнгийн төсвийн гүйцэтгэл 2019 онд 53.2%-тай хамгийн бага байсан бол 2022 онд сайн буюу 98.7% гүйцэтгэлтэй гарсан байна.

Хүснэгт 23. Хөрөнгө оруулалтын төсөв ба гүйцэтгэл /сая.төг/

Он	Тухайн онд санхүүжих дүн	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
2012	49,334.9	44,826.0	90.9%
2013	42,721.3	28,186.0	66.0%
2014	25,687.9	19,237.5	74.9%
2015	20,763.0	17,648.6	85.0%
2016	18,164.6	15,439.9	85.0%
2017	7,337.5	5,638.6	76.8%
2018	15,906.6	13,020.9	81.9%
2019	43,738.9	23,289.5	53.2%
2020	30,854.2	23,949.5	77.6%
2021	32,830.4	32,121.0	97.8%
2022	35,162.9	34,692.1	98.7%
Нийт	322,502.1	258,049.4	80.0%

2010-2023 онд давхардсан тоогоор он дамжуулан нийт 319 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Үүнээс спортын ордны барилга хамгийн их баригджээ.

Хүснэгт 24. Хөрөнгө оруулалт байгууллагын төрлөөр

Он	Авто парк	Спорт заал	Спортын ордон	Талбай	Усан бассейн	Нийт
2010			12	1		13
2011			29	3		32
2012		5	15	6		26
2013		1	9		1	11

Он	Авто парк	Спорт заал	Спортын ордон	Талбай	Усан бассейны	Нийт
2014		1	19		2	22
2015		1	11		2	14
2016		2	9			11
2017		1	8		1	10
2018		5	10	1		16
2019		21	15	6	2	44
2020	1	16	15	5	3	40
2021		14	17	2	2	35
2022		16	22	5	2	45
Нийт	1	83	191	29	15	319

Салбарын хөрөнгө оруулалтын 2010-2022 онд батлагдсан төсөл арга хэмжээг хамруулан судалгаа хийхэд ашиглалтад орох хүртэлх барилгын ажлын үргэлжлэх хугацаа дунджаар 4.1 жил байна.

Гэхдээ 2010 онд анх төсөв нь батлагдсанаас хойш 2019 он хүртэл 10 жил үргэлжилсэн спортын ордны 1 барилга, 2022 ашиглалтад орсон спортын ордны 4 барилга, 2023 онд ашиглалтад орох 14 жил үргэлжилж буй спортын ордны 1 барилга байна.

Хүснэгт 25. Хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэл, оноор

Эхлэх он	Дуусах он	Авто парк	Спорт заал	Спортын ордон	Талбай	Усан бассейны	Нийт	Төсвийн үргэлжлэх хугацаа
2005	2010			1			1	6
2008	2010			2	1		3	3
2008	2011			1			1	4
2008	2016			1			1	9
2010	2010			6			6	1
2010	2012			8			8	3
2010	2014			1			1	5
2010	2019			1			1	10
2010	2022			4			4	13
2010	2023			1			1	14
2011	2011			15	3		18	1
2011	2012			2			2	2
2012	2012		4	8	6		18	1
2012	2013			1		1	2	2
2012	2014			2			2	3
2012	2016		1	1			2	5
2012	2017		1				1	6
2012	2020			2			2	9
2013	2014			2			2	2
2013	2023			1			1	11
2014	2014			2			2	1

Эхлэх он	Дуусах он	Авто парк	Спорт заал	Спортын ордон	Талбай	Усан бассейн	Нийт	Төсвийн үргэлжлэх хугацаа
2014	2015			1			1	2
2014	2017					1	1	4
2014	2018			1			1	5
2014	2021			1			1	8
2018	2018		2		1		3	1
2018	2019		3	1			4	2
2018	2023			1			1	6
2019	2019		11	5	5		21	1
2019	2020		3			1	4	2
2019	2022		2			1	3	4
2019	2023		5	3	1		9	5
2020	2020	1	2	1	2	1	7	1
2020	2021		2	1			3	2
2020	2022		2	1	1		4	3
2020	2023		4	2	1		7	4
2021	2021			1		1	2	1
2021	2022		1				1	2
2021	2023		5	3	1		9	3
2021	2024			1			1	4
2022	2022			1	2		3	1
2022	2023		1	3			4	2
2022	2024			2		1	3	3
		1	49	91	24	7	172	4.1

Эх үүсвэр: Сангийн яам, 2010-2022

Барилга байгууламжийн ашиглалтад орох хугацаа төлөвлөснөөс хойшлох нь төсөвт өртөг нэмэгдэх гол хүчин зүйл болж эдийн хувьд үр ашиггүй нөхцөл байдал үүсдэг. Иймд төсөл арга хэмжээний ТЭЗҮ-ийг анхнаас нь зөв тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлж, шаардлагатай төсөлд л хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Нийт 5 жилээс дээш баригдсан болон баригдаж буй 27 төсөл арга хэмжээ, үүнээс 10-аас дээш үргэлжилж буй 7 төсөл арга хэмжээ байгаа нь салбарын барилга байгууламжийн төсөл арга хэмжээний үргэлжлэх хугацааны дундаж 4.1 жил байхад нөлөөлж байна.


Төсөл арга хэмжээний 5-аас дээш жил үргэлжлэх хугацаа бүхий төсөл арга хэмжээг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 26. Хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэл, 5-аас дээш жил

Төсөл арга хэмжээ, үргэлжилсэн оноор	Спорт заал	Спортын ордон	Талбай	Нийт
2005-2010		1		1
Спортын ордон, 600 суудал /Өвөрхангай/		1		1
2008-2016		1		1
Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/		1		1
2010-2014		1		1
Спорт цогцолбор, 700 суудал /Сүхбаатар, Баруун-Урт/		1		1
2010-2019		1		1
Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/		1		1
2010-2022		4		4
Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/		1		1
Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/		1		1
Нийслэлийн спорт цогцолбор, 1000 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/		1		1
Спорт цогцолбор, 2200 суудал /Дархан-Уул, Дархан сум/		1		1
2010-2023		1		1
Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Налайх дүүрэг/		1		1
2012-2016	1	1		2
Спорт заалны барилга /Дорнод, Хэрлэн, 2 дугаар баг/	1			1
Спорт цогцолборын барилга, 500 суудал /Ховд, Манхан сум/		1		1
2012-2017	1			1
Спорт заалны барилга /Булган, Хангал сум, Хялганат тосгон/	1			1
2012-2020		2		2
Спорт цогцолборын барилга /Дорноговь, Хатанбулаг сум/		1		1
Спорт цогцолборын барилга /Завхан, Улиастай сум/		1		1
2013-2023		1		1
Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах /Архангай, Эрдэнэбулган сум/		1		1
2014-2018		1		1
Спорт цогцолборын барилга, 700 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/		1		1
2014-2021		1		1
Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/		1		1
2018-2023		1		1
Оюуны спортын ордны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/		1		1
2019-2023	5	3	1	9
Наадмын талбайн барилгын дуусгал /Дундговь, Сайнцагаан сум/			1	1
Соёл, спорт цогцолборын барилга /Хөвсгөл, Мөрөн сум/		1		1
Спорт заалны барилга /Говь-Алтай, Бигэр сум/	1			1
Спорт заалны барилга /Говь-Алтай, Бугат сум/	1			1
Спорт заалны барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	1			1
Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал сум/	1			1
Спорт цогцолборын барилга, 105 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум/		1		1

Биеийн тамир, спортын салбарт 2010-2022 оны 13 жилийн хугацааны хөрөнгийн зардлыг багцалбал, нийтдээ 322.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөв батлагдаж, 172 барилгын ажлыг эхлүүлж, 100 барилгыг ашиглалтад оруулж, 258.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлсэн байна. Нийт ашиглалтад орсон 134 төсөл арга хэмжээний 67 буюу 50.0% хувь нь спортын ордны барилга байна. /Зураг 26/

Зураг 26. 2010-2022 онд баригдсан барилгын тоо, зориулалтаар



Эх үүсвэр: Сангийн яам, 2023


8. ТӨСВИЙН ХАНГАЛТТАЙ БАЙДАЛ

Биеийн тамир, спортын салбар 2022 оны жилийн эцсийн байдлаар 1.8 тэрбум төгрөгийн авлагатай болсон нь 2021 онтой харьцуулахад 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлага нэмэгдэх гол шалтгаан нь Засгийн газрын 2022 оны 494 дүгээр тогтоолоор Монголын бүх ард түмний болон үндэсний спортын наадмын медальт байрны тамирчин, дасгалжуулагчдын мөнгөн шагналын 1,502.0 сая төгрөгийн өглөгийг Сангийн яамнаас авах авлагаар /Татаас, санхүүжилтийн авлага/ тооцож бүртгэснээс шалтгаалсан байна.⁶

Нийт өр төлбөрийн хувьд 2022 оны санхүүгийн тайлангаар 6.9 тэрбум төгрөгийн өр төлбөртэй гарсан бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 2.3 тэрбум төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд барьцаа хөрөнгийн данснаас БТСУХ-ны 5,731.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт олгосноос шалтгаалжээ. Өр төлбөр дансны үлдэгдэлд БТСУХ-ны барьцаа хөрөнгийн дансны 5,825.8 сая, Үндэсний шигшээ багийн бэлтгэл сургалтын төвийн 733.8 сая, Буянт-Ухаа спортын ордны 271.1 сая, Баян-Өлгийн аймгийн 59.4 сая, Төв аймгийн БТСГ-ын 22.4 сая төгрөгийн томоохон өр төлбөр бүртгэлтэй байна.⁷

Салбарын хувьд 2020-2022 оны тайлант хугацаанд авлага 1.6 тэрбум төгрөгөөр буурсан бол, өглөг 5.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зураг 27. Салбарын нийт өр төлбөр ба авлага, сая төгрөгөөр



Эх үүсвэр: БТСУХ, Аудитын тайлан 2023

⁶Үндэсний аудитын газар, СНАГ-2023/10/НА-СТА-ТТЗ, хуудас 14
⁷Үндэсний аудитын газар, СНАГ-2023/10/НА-СТА-ТТЗ, хуудас 17

9. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ЗАРДЛЫН ӨГӨӨЖ

Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг баталдаг. Төсвийн ерөнхийлөн захирагч (сайд) нар төсвийн жил дууссаны дараа төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, СЯ-нд ирүүлэх үүргийг Төсвийн тухай хуулиар хүлээдэг. Уг тайланд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлтийг багтаасан байх ёстой. СЯ-аас Монгол Улсын жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэж дараа оны 5 дугаар сарын 10-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх ба аудитын байгууллагын дүгнэлт гарсны дараа УИХ-аар хэлэлцүүлж, гүйцэтгэлийг батлуулдаг.

Монгол Улсын 2020, 2021, 2022 оны төсвийн тухай хуулиудаар баталсан биеийн тамир, спортын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах хүснэгт 24-д харьцуулан харуулав.

Хүснэгт 27. Биеийн тамир, спорт хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

	Хөтөлбөрийн үр дүнгийн чанарын ба тоон шалгуур үзүүлэлтүүд	2020 оны зорилтот түвшин	2021 оны зорилтот түвшин	2022 оны зорилтот түвшин
1	Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /нийт хүн амд эзлэх хувиар/	47	47	47
2	Олимпын наадамд оролцох эрхийн тоо	-	-	-
3	Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо	150	120	120

Монгол Улсын 2020, 2021, 2022 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан биеийн тамир, спортын хөтөлбөрийн 3 шалгуур үзүүлэлтээс “Олимпын наадамд оролцох эрхийн тоо” шалгуур үзүүлэлтийг хэдийгээр цаг хугацааны циклтэй ч 2017 оноос хойш тодорхойлоогүй, бусад 2 үзүүлэлтийг тогтмол хүрэх түвшнээр батлуулсан ба зорилтот түвшнийг ямар нэг ахиц дэвшил, өөрчлөлтгүй жил бүр ижил хэмжээгээр авч байжээ.

Хөтөлбөрийн хүрэх үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг Төсвийн тухай хуулиар баталдаг боловч хөтөлбөрийн үр дүнгийн томъёолол хуульд тусгагдахгүй байна. Биеийн тамир, спортын хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд зөвхөн тоон шалгуур үзүүлэлтүүд бөгөөд төсвийн хөрөнгөөр хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг бус зөвхөн хийх ажил, үйлчилгээний гарцын үзүүлэлтийг хэмжих шалгуур төдий байна. Цаашид байгууллагуудаас авдаг захиргааны тоо мэдээллийг сайжруулах, албан ёсны статистик үзүүлэлтүүдийг шинэчлэх, салбарын хувийн хэвшилд ажиллагчдын тооны статистик мэдээлэл зэргийг тооцдог болох шаардлагатай байна.

Манай улсын хувьд Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгын 244 шалгуур

үзүүлэлтийн 20 шалгуур үзүүлэлтийг буюу дөнгөж 8% нь манай хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд ашигласан нь хангалтгүй байгаа учраас цаашид өөрийн орны бодлогын баримт бичигт ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийг тусгахыг эрмэлзэх шаардлагатай байна.

Спортын салбарт оруулсан 1 ам.долларын хөрөнгө оруулалт бүр 3-124 ам.долларын өгөөжтэй байдаг.

ЮНЕСКО-ийн судалгаанд тусгагдсанаар 4 насанд хүрэгчдийн нэг нь, өсвөр насны 5 хүүхэд тутмын 4-с дээш нь, ялангуяа залуу эмэгтэйчүүд хангалттай идэвхтэй байдаггүй. Цар тахлын улмаас муудаж 41 хувиар идэвхтэй хөдөлгөөн буурсан. Юнеско-гийн санал асуулгад хамрагдсан биеийн тамирын багш нарын 70 хувь нь цар тахлын үеэр сурагчдын бие, сэтгэцийн эрүүл мэнд муудсан байна. Дэлхийн 194 орны баримтаас үзэхэд нийт улс орнуудын 50-иас бага хувь нь биеийн тамирын дасгалын талаар үндэсний бодлого баримталж, үүний 40-өөс бага хувь нь үйл ажиллагаа явуулдаг. Covid-19 тахал нь биеийн тамирын дасгал сургуулилтыг сурталчлах ажлыг зогсоосон ба мөн бусад бодлогын хэрэгжилтэд нөлөөлж, олон нийтийн биеийн тамирын дасгал хийх хүртээмж, боломжуудын тэгш бус байдлыг нэмэгдүүлсэн байна.

Спортоор бий болсон нийгмийн өгөөжийн талаарх олон улсын зардал-үр ашгийн нотолгоог саяхан системчилсэн дүн шинжилгээ хийхдээ 1:3 ба 1:124 харьцаатай байгааг мэдээлсэн (Госселин, Бокканфусо, Лаберге, 2020). Энгийнээр хэлбэл, өндөр чанартай судалгааны судалгаагаар спортын арга хэмжээнд оруулсан 1 ам.доллар бүр 3-аас 124 ам.долларын өгөөжтэй байдаг. Үр өгөөжийн хүрээний зөрүү нь янз бүрийн судалгааны тайланд судлагдсан хөндлөнгийн зорилтууд болон зорилтот бүлгүүдийн өргөн цар хүрээтэй байдлаас үүдэлтэй. Биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаас урьдчилан сэргийлэхэд спортын үзүүлэх нөлөө хамгийн өндөр юм.

Спорт, идэвхтэй хөдөлгөөний шууд нөлөө үзүүлдэг хүчин зүйлсийн жагсаалт:



1. Биеийн эрүүл байдал

Зүрх судасны өвчин, цус харвалт, цусны даралт ихсэх, зарим төрлийн хорт хавдар, ясны сийрэгжилт, 2-р хэлбэрийн чихрийн шижин гэх мэт 30-аас доошгүй архаг өвчинд дасгал хийх ач тустайг нотолсон байна. (Thornton et al., 2016)

2. Сэтгэцийн эрүүл байдал

Дасгал хөдөлгөөн нь, сэтгэлийн хямрал, стрессийг бууруулдаг; ба амьдралын сэтгэл ханамж, амьдрах таатай мэдрэмж гэх мэт сайн зүйлсийг бий болгодог.

3. Хувь хүний хөгжил

Спортын үйл ажиллагаа нь өөрийгөө сайжруулах, өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх, эрх мэдлийг нэмэгдүүлэх; гэмт хэрэг, нийгмийн эсрэг зан үйлээс зайлсхийхэд тусалдаг; сайн дурын идэвхийг нэмэгдүүлэх гэх мэт ашиг тустай.

4. Нийгэм, олон нийтийн хөгжил

Спорт нь олон нийтийн эв нэгдлийг сайжруулж, сэтгэл дундуур байгаа залуучуудын оролцоог дэмжиж, эмэгтэйчүүд, охид, түүнчлэн эмзэг нөхцөл байдалд байгаа хүмүүсийг хамруулахыг дэмждэг.

5. Эдийн засгийн өсөлт

Спорт нь орон нутгийн эдийн засагт зориулсан хэрэглээний зардлыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгож, ажил мэргэжлийн боломжийг дээшлүүлж, нийгмийн өргөн хүрээний үнэ цэнийг бий болгодог.⁸

2021 оны ЮНЕСКО-гийн 117 орноос мэдээлэл цуглуулсан чанарын судалгаагаар КОВИД-19 нь залуучуудын дунд биеийн хөдөлгөөнийг 41%-иар бууруулж, сэтгэцийн эрүүл мэндийг 200 хувиар нэмэгдсэн гэж тооцоолжээ. Мөн Юнеско-гийн мэдээлснээр биеийн тамирын хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд дэлхийн олон оронд, тэр дундаа хамгийн баян оронд буурч байна гэж мэдээлсэн. (Hardman, Routen and Tone, 2014). Хөдөлгөөнгүй байдлын түвшнийг 25 хувиар бууруулснаар дэлхийн хэмжээнд жилд 1.3 сая хүн нас барахаас сэргийлнэ (Lee et al., 2012; WHO, 2010).

Хэрэв арга хэмжээ авахгүй бол хөдөлгөөний дутагдлаас үүдэлтэй эдийн засгийн дарамт хурдтай нэмэгдэж, ДЭМБ-ын тооцоолсноор 2020-2030 он хүртэл ойролцоогоор 500 сая хүн зүрхний өвчин, таргалалт, чихрийн шижин болон бусад халдварт өвчин тусах бөгөөд үүний үр дүнд жил бүр 27 тэрбум долларын зардал гарна гэж тооцоолсон.

Монгол улсын хувьд тус салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт ямар түвшинд байгааг дүгнэхэд хангалттай найдвартай мэдээллийн эх үүсвэр байхгүй байна.

Шигтгээ. “ActiveSG” Сингапур улсын үндэсний хөдөлгөөн



⁸Impact investment in Sport, 2023, UNESCO

Шигтгээ. “ActiveSG” Сингапур улсын үндэсний хөдөлгөөн

ActiveSG бол Sport Singapore-аас санаачилсан үндэсний хөдөлгөөн юм. Энэ нь боломжийн үнээр өргөн хэмжээний хөтөлбөр, үйл ажиллагаануудаар дамжуулан бүх насны бүлгүүдэд спорт, эрүүл амьдралыг дэмжих зорилготой юм. Гар утсан дээрх дагалдах программтай хамт ирдэг уг хөтөлбөр нь Сингапурчууд болон байнгын оршин суугчдад үнэ төлбөргүй байдаг.

Энэхүү төслийн хүрээнд Сингапур улсын хэмжээнд 29 спортын цогц үйлчилгээ үзүүлэх төвүүдийг байгуулсан ба эдгээр спортын төвүүдэд дасгал хийх, усанд сэлэх, сагсан бөмбөг тоглох, цаашлаад зарим төвүүдэд хөл бөмбөг тоглох талбайтай байна. Бүртгэлгүй иргэд 1 удаа үйлчлүүлэхэд ердөө 2-3.5 Сингапур долларын /5,200-9,100 төгрөг/ үнэтэй байна.

Спортын амьдралын хэв маягийг сурталчлах, спортын шинэлэг, хөгжилтэй, утга учиртай туршлагаар дамжуулан олон нийтийг татан оролцуулах эрхэм зорилгынхоо хүрээнд Sport Singapore (SportSG) нь спортын амьдралын хэв маягийг төлөвшүүлэхийн тулд бүх насны болон спортын ур чадвар бүхий сингапурчуудад зориулсан олон төрлийн, эрч хүчтэй санаачлагуудыг хөгжүүлэхийн тулд бие даан, холбогдох агентлагуудтай идэвхтэй хамтран ажилладаг.

Салбарын 2013-2022 оны хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, хүрсэн үр дүнг хүснэгт 28-д харуулав.

Хүснэгт 28. Биеийн тамир, спорт хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /нийт хүн амд эзлэх хувиар/	Олимпын наадамд оролцох эрхийн тоо	Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо
2013	Зорилтот түвшин	25.8	3	
	Хүрсэн түвшин			
2014	Зорилтот түвшин	25.8	10	
	Хүрсэн түвшин			
2015	Зорилтот түвшин	26.5	15	150
	Хүрсэн түвшин	33.5	18	187
2016	Зорилтот түвшин	35	35	100
	Хүрсэн түвшин	35	35	110
2017	Зорилтот түвшин	40		100
	Хүрсэн түвшин	23.7		116
2018	Зорилтот түвшин	47		150
	Хүрсэн түвшин	35.02		243
2019	Зорилтот түвшин	47		150
	Хүрсэн түвшин	17.9		112
2020	Зорилтот түвшин	47		150
	Хүрсэн түвшин	37.5		46

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /нийт хүн амд эзлэх хувиар/	Олимпын наадамд оролцох эрхийн тоо	Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо
2021	Зорилтот түвшин	47		120
	Хүрсэн түвшин			
2022	Зорилтот түвшин	47		120
	Хүрсэн түвшин			

Салбарын үйл ажиллагааны үр дүнгийн 4 үзүүлэлт /А-С/ болон салбарын зардлын зарим төрөл хооронд уялдаа байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор корреляцийн хамаарлын шинжилгээ хийв. Үүнд салбарын урсгал ба хөрөнгийн зардал, цалингийн зардал (D-F), Улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих, Олон улсын тэмцээн, уралдаанд оролцох, Нийтийн биеийн тамирыг дэмжих, Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих уран бүтээл хийлгэх зориулалтаар 2013-2022 онд зарцуулсан (G-J) зардлуудыг үйл ажиллагааны үр дүнгийн 3 үзүүлэлттэй хамаарах корреляцийн коэффициентийг тооцож дараах хүснэгт 29-д харуулав.

Хүснэгт 29. Хамаарлын шинжилгээ

Хамаарал тооцсон үзүүлэлт	А.Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /нийт хүн амд эзлэх хувиар/	В.Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо	С.Допингийн зөрчилтэй тамирчдын тоо
D.Урсгал зардал	0.3580	-0.2101	0.4370
E.Хөрөнгө оруулалт	0.1983	0.1664	-0.7277
F.Цалингийн сан, НДШ	0.4108	-0.2137	-0.4460
G.Улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих	0.3714	0.1910	-0.6331
H.Олон улсын тэмцээн, уралдаанд оролцох	-0.8924	-0.5513	0.0961
I.Нийтийн биеийн тамирыг дэмжих	0.4944	0.5304	0.6045
J.Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих	0.0492	0.0492	-0.7315

Нийтийн биеийн тамираар хичээллэгчдийн тоо нь урсгал зардалтай эерэг, сул хамааралтай /0.3580/, цалингийн сан, НДШ-тэй мөн адил эерэг сул хамааралтай /0.4108/, Харин нийтийн биеийн тамирыг дэмжих зардалтай эерэг, дундаж хамааралтай /0.4944/ байна. Өөрөөр хэлбэл нийтийн биеийн тамирыг дэмжих зардлыг нэмэгдүүлэхэд биеийн тамираар хичээллэгчдийн тоо 0.49 коэффициентээр нэмэгдэхээр байна.

Харин олон улсын тэмцээн, уралдаанд оролцох зардал нь олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоотоо урвуу, дундаж хамааралтай /0.5513/ байна. Энэ нь “Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо” гэсэн шалгуур үзүүлэлтийг буруу төлөвлөсөнтэй холбоотой бөгөөд шалгуур үзүүлэлтийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

“Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих” зардал нь “Допингийн зөрчилтэй тамирчдын тоо” үзүүлэлттэй сөрөг, хүчтэй хамааралтай /-0.7315/ байгаа нь сайн үзүүлэлтэй байна.

Хүснэгт 30. Хамаарлын шинжилгээнд хэрэглэсэн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Он	Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /нийт хүн амд эзлэх хувиар/	Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо	Допингийн зөрчилтэй тамирчдын тоо	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Цалингийн сан, НДШ	Улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих	Олон улсын тэмцээн, уралдаанд оролцох	Нийтийн биеийн тамир	Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих
2013	25.8		1	20,549.4	28,186.0	2,409.3				
2014	25.8		3	20,878.7	19,237.5	2,615.9				
2015	26.5	150		17,157.8	17,648.6	1,738.6				
2016	35	100	3	21,534.8	15,439.9	1,639.3	7,018.1	3,058.7		
2017	40	100	5	20,694.0	5,638.6	1,464.9	4,696.9	1,934.4	162.6	200.0
2018	47	150	8	24,670.8	13,020.9	1,477.2	5,412.2	1,491.4	2,444.2	0.0
2019	47	150	2	12,373.0	23,289.5	1,549.5	6,858.9	1,084.7	1,186.0	200.0
2020	47	150	3	26,685.7	23,949.5	3,206.6	8,944.6	142.9	626.4	455.0
2021	47	120		24,985.2	32,121.0	8,974.2	9,411.6	557.6	259.3	
2022	47	120		27,117.7	34,692.1	9,177.5	7,650.0	239.0	1,674.4	

10. ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д төсвийн ил тод байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэхдээ төсвийн байгууллагууд нь төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих, төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор тус тус хангахыг хуульчилсан байдаг. Түүнчлэн Төсвийн тухай хуульд хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх тухай заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл болон ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагууд нь төсөв, санхүүгийн мэдээллээ тодорхой давтамжийн дагуу www.shilendans.mn цахим хуудсанд нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй. Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн аудитын тайланд дурдсанаар 2020 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл нь дараа онд мэдээлэх тул хугацаа нь болоогүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан байна. Харин 2022 онд шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 311 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

Хэдийгээр тухайн оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагч, шууд захирагчаар сараар гаргаж цахим хуудсанд ил тод байршуулж байгаа боловч, төсвийн зардлыг эдийн засгийн ангиллаар харуулдаг тул энгийн иргэд, олон нийт ийм мэдээлэлд боловсруулалт хийж, дүн шинжилгээ хийх, харьцуулалт хийх бараг боломжгүй байна.

11. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой УЯЛДСАН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Энэхүү үзүүлэлтүүд нь Тогтвортой хөгжлийн зорилтод спорт, биеийн тамир, биеийн тамирын оруулах хувь нэмрийг хянах, үнэлэх үндсэн цогц хүчин зүйл юм. Эдгээр үзүүлэлтүүд нь үндэсний болон байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, спорт, биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, ТХЗ-ын талаарх нийтлэг мэдээллийг сайжруулах техникийн нөөцөөр хангахад чиглэсэн.

Энэхүү жагсаалтад үндэсний, спортын онцлог эсвэл байгууллагын тэргүүлэх чиглэл, нөхцөл байдлын хүчин зүйлд үндэслэн ашиглах боломжтой ТХЗ-д хамаарах спорт, биеийн тамирын дасгал, биеийн тамирын дасгалын үзүүлэлтүүдийн бүрэн багцыг агуулдаг. Эдгээр "2-р ангиллын шалгуур үзүүлэлтүүд"-ийг Казанийн үйл ажиллагааны төлөвлөгөөний тэргүүлэх ач холбогдол бүхий 10 ТХЗ болон холбогдох нөлөөллийн хүрээнд сэдэвчилсэн байдлаар бүлэглэсэн.

Систем, хүн амын түвшний өөрчлөлт, институци болон байгууллагын түвшний өөрчлөлт, олон нийтийн түвшний өөрчлөлт зэрэгт чиглэсэн 27 "Ангилал 1 үзүүлэлт"-ийг агуулсан. Эдгээр 1-р ангиллын шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол цуглуулах зорилготой бөгөөд оролцогч талуудад тухайн шалгуур үзүүлэлтүүдийн орон нутгийн нөхцөл байдал, хөгжлийн тэргүүлэх чиглэлд хамаарах байдал дээр үндэслэн 2-р ангиллын шалгуур үзүүлэлтүүдийг сонгохоор төлөвлөсөн.¹¹

Ангилал 1:

Нийтлэг үзүүлэлтүүд – бүх улс орнуудаас тогтмол цуглуулах дэлхийн үзүүлэлтүүдийн багц. 1-р ангиллын шалгуур үзүүлэлтүүд нь үзэл баримтлалын хувьд тодорхой бөгөөд одоо байгаа эсвэл санал болгож буй мэдээллийн эх сурвалжийг тодорхойлсон, өөрөөр хэлбэл олон улсад тогтсон хэмжилтийн арга зүй, стандартыг аль хэдийн мөрдөж эхэлсэн эсвэл нэвтрүүлэх боломжтой үзүүлэлтүүд юм.

Ангилал 2:

ТХЗ-д хамаарах үзүүлэлтүүд – нэн тэргүүнд тавигдсан ТХЗ-д спорт, биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний оруулж болох хувь нэмрийг нарийвчлан хэмждэг илүү өргөн хүрээтэй шалгуур үзүүлэлтүүд. Эдгээр нь хөгжлийн тэргүүлэх чиглэлд тулгуурлан өргөн хүрээний оролцогч талуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний хүчин чармайлтыг цаашид мэдээлэх зорилготой юм. 2-р ангиллын шалгуур үзүүлэлтүүдийг ашиглах зорилго нь холбогдох оролцогч талуудын бусад түвшний мэдээлэл цуглуулах (бүс нутгийн, үндэсний болон дэд үндэсний) тогтмол хэрэглээг дэмжих, нийтлэг хэл бий болгоход оршино.

¹¹*Sport and SDG Indicators, Indicators to measure the contribution of sport, physical education and physical activity to the Sustainable Development Goals, Commonwealth Secretariat 2020*

ТХЗ 3: Бүх насны хүмүүсийн эрүүл амьдралыг баталгаажуулж, сайн сайхан байдлыг дэмжинэ

СПОРТ БОЛОН ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ОРОЛЦОО

Ангилал 1

Бүх насны хүмүүсийн эрүүл амьдрал, сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 1: Спорт, фитнес, идэвхтэй амралт зугаалгаар хичээллэх нь өөртөө болон гэр бүл, нийгэмд эерэг нөлөө үзүүлдэг гэж мэдээлсэн хүн амын хувь

Үзүүлэлт 2: i) насанд хүрэгчид, ii) өсвөр насны хүн амын бие махбодын хувьд хангалттай идэвхтэй хүмүүсийн хувь

Үзүүлэлт 3: долоо хоногт нэг удаа спорт, дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэг хүн амын хувь

Үзүүлэлт 5: долоо хоногт нэг удаа спортоор хичээллэж, дасгал хийдэг эмэгтэйчүүдийн хувь

Ангилал 2

Бүх насны хүмүүсийн эрүүл амьдрал, сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн үзүүлэлтүүд:

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
S3.1	Долоо хоногт нэг удаа спорт, фитнес, амралт чөлөөт цагаараа идэвхтэй хөдөлгөөн хийдэг насанд хүрэгчдийн хувь	3.4.1
S3.2	Долоо хоногт нэг удаа спорт, фитнес, амралт чөлөөт цагаараа идэвхтэй хөдөлгөөн хийдэг өсвөр насныхны хувь	3.4.1
S3.3	Хөдөлгөөн багатай хүн амыг татан оролцуулахад чиглэсэн биеийн тамирын дасгал сургуулилт, сурталчилгааны ажлыг олон нийтийн хэмжээнд хэрэгжүүлсэн орнуудын хувь	3.4.1 17.16.1
S3.4	Сүүлийн 2 жилийн хүн амд суурилсан спорт, фитнес, эсвэл амралтын оролцооны судалгаа	3.4.1 17.16.1
S3.5	Спортоор дамжуулан эрүүл мэндийг сурталчилж байгаа спортын байгууллагын эзлэх хувь	3.3.1-3.3.5
S3.6	Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр хөрөнгө оруулдаг спортын байгууллагын тоо	3.4.2
S3.7	Нийтийн задгай талбайг сурталчлах цэцэрлэгт хүрээлэн, гол горхи, далайн эрэг болон олон нийтийн үнэгүй ашиглах боломжтой бусад газрууд гэх мэт идэвхтэй хөдөлгөөнд чиглэсэн бодлого, төлөвлөгөөтэй улс орнуудын хувь	3.4.1 11.7
S3.8	Идэвхтэй гэж ангилагдсан ахмад настнуудын хувь -ДЭМБ-аас 65 ба түүнээс дээш насны хүмүүсийн тодорхойлолт	3.4.1
S3.9	Өмнөх жилийн олон нийтийн оролцоотой спортын арга хэмжээний дор хаяж нэгт оролцсон хүн амын хувь	3.4.1

ТХЗ 4: Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролыг баталгаажуулж, насан туршийн боловсролыг дэмжинэ

БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨН

Ангилал 1

Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролыг хангах, насан туршийн боловсролыг дэмжихтэй холбоотой үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 4: i) бага, ii) дунд сургуулиуд долоо хоногт биеийн тамирын хичээлийн хамгийн бага минут нь ангиас хамаарч долоо хоногт 120/180 минут байсан сургуулийн эзлэх хувь

Үзүүлэлт 11: i) бага, ii) дунд сургуулийн биеийн тамирын чиглэлээр мэргэшсэн багш нартай сургуулиудын хувь

Үзүүлэлт 12: ЮНЕСКО-гийн QPE-ийн бодлогын удирдамжаар тодорхойлсон чанартай биеийн тамирын хичээлийг бүрэн/хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлж буй сургуулиудын хувь.

Ангилал 2

Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролыг хангах, насан туршийн боловсролыг дэмжихтэй холбоотой үзүүлэлтүүд:

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЭ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
S4.1	Биеийн тамирын хичээлийг бие даасан хичээл болгон явуулдаг сургуулиудын хувь	3.4.1
S4.2	Хичээлийн цагийн дараа спортоор хичээллэдэг сургуулиудын хувь	3.4.1
S4.3	Өсвөр насныханд өрсөлдөөнт бус идэвхтэй хөдөлгөөний клубт хамрагдах боломжоор хангадаг сургуулийн эзлэх хувь	3.4.1 4.7
S4.4	Биеийн тамирын салбарт оруулсан улсын боловсролын төсвийн эзлэх хувь	4.6
S4.5	Чанартай, хүртээмжтэй бие бялдрын боловсролыг дэмжихэд хангалттай барилга байгууламж, тоног төхөөрөмж байгаа талаар мэдээлсэн сургуулиудын хувь	3.4.1 16.7.1
S4.6	Спорт, биеийн тамир, дасгал хөдөлгөөнтэй холбоотой сургалт явуулдаг дээд боловсролын байгууллагын тоо	4.3.1 8.6.1
S4.7	Сүүлийн 12 сарын хугацаанд залуучууд, насанд хүрэгчдийн спорт, биеийн тамир, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхтэй холбоотой албан болон албан бус боловсрол олгох сургалтад хамрагдсан хувь, хүйсээр	4.3.1 8.6.1
S4.8	Охидын биеийн тамирын дасгалд заавал хамрагдуулдаг улс/сургуулиудын хувь	3.4.1 5.1 5.1
S4.9	Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлгүй хүмүүс нэг төрлийн биеийн тамирын хичээлд хамрагддаг улс орон, сургуулиудын хувь	3.4.1 10.3 10.3.1
S4.10	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг биеийн тамирын дасгалд хамруулах талаар тусгайлан стратеги хэрэгжүүлсэн улс орон, сургуулиудын хувь	3.4.1 10.3 10.3.1
S4.11	Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг чанартай биеийн тамирын дасгал сургуулилтад оролцоход тохирсон дэд бүтцийг шийдсэн сургуулиудын эзлэх хувь	4.А.1 4.3.1 4.3.1
S4.12	Спорт, биеийн тамир, идэвхтэй дасгал хөдөлгөөнтэй холбоотой сургалт явуулдаг дээд боловсролын байгууллагын тоо	4.3.1
S4.13	Сүүлийн 12 сарын хугацаанд залуучууд, насанд хүрэгчдийн спорт, биеийн тамирын боловсрол, идэвхтэй хөдөлгөөн эсвэл чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэхтэй холбоотой албан болон албан бус боловсрол, сургалтад хамрагдсан хувь, хүйсээр	4.3.1

ТХЗ 5: Жендэрийн тэгш байдлыг хангаж, бүх эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах

НИЙГМИЙН НӨЛӨӨЛӨЛ, ОРОЛЦОО, ТЭГШ БАЙДАЛ

Ангилал 1

Бүх охид, эмэгтэйчүүдийн жендерийн тэгш байдлыг хангах, эрх мэдлийг нэмэгдүүлэхтэй холбоотой үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 1: Спорт, фитнесс, идэвхтэй амралт зугаалгаар явдаг нь өөртөө болон гэр бүл, нийгэмд эерэг нөлөө үзүүлдэг гэж мэдээлсэн хүн амын хувь

Үзүүлэлт 5: долоо хоногт нэг удаа спортоор хичээллэж, дасгал хийдэг эмэгтэйчүүдийн хувь

Үзүүлэлт 6: Нийт хүн амтай харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй хүн долоо хоногт нэг удаа спорт, фитнесс, идэвхтэй амралт (чөлөөт цаг)-д оролцох магадлал

Үзүүлэлт 9: спортод сайн дурын ажил хийдэг хүн амын хувь

Үзүүлэлт 15: Үндэсний спортын байгууллагуудын i) Тэргүүн, ii) Удирдах зөвлөлийн гишүүд, iii) Гүйцэтгэх захирал/Ерөнхий нарийн бичгийн дарын албан тушаал хашдаг эмэгтэйчүүдийн хувь

Үзүүлэлт 16: i) жендэрийн тэгш байдлын стратеги, ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг спортод хамруулах стратегид хөрөнгө оруулалт хийсэн үндэсний спортын байгууллагууд / гишүүн байгууллагуудын хувь

Ангилал 2

Бүх охид, эмэгтэйчүүдийн жендерийн тэгш байдлыг хангах, эрх мэдлийг нэмэгдүүлэхтэй холбоотой үзүүлэлтүүд:

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
S5.1	Эрэгтэй хүн амын хувь болон эмэгтэй хүн амын хувь хоорондын хангалттай идэвхтэй хөдөлгөөнтэй байгаа ялгаа	3.4.1
S5.2	Долоо хоногт нэг удаа спортоор хичээллэж, дасгал хийдэг эрэгтэй хүн амын хувь, эмэгтэй хүн амын хувь хоорондын ялгаа	3.4.1
S5.3	Спорт, биеийн тамирын салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн хувь *сайн дурынхныг оруулахгүй	8.5.2 5.5.2
S5.4	Жендерийн тэгш байдлыг хангах стратеги эсвэл төсөвт тусгагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөтэй спортын байгууллага, гишүүн байгууллагуудын хувь	5.1.1 5.С.1
S5.5	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн 1. Эрэгтэй 2. эмэгтэй хүмүүст зориулсан хүйсийн агуулга бүхий спортын нийтлэлийн хувь	5.1.15.5 10.3
S5.6	Эмэгтэйчүүд, охидод зориулсан спортын хэвлэл мэдээллийн (уламжлалт болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл) эзлэх хувь	5.1.1 5.5 5.с.1
S5.7	1. үндэсний хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо 2. санхүүждэг спортын байгууллага/ гишүүн байгууллагууд спорт, биеийн тамир, биеийн тамирын дасгал хөдөлгөөнтэй холбоотой хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хүйсээр нь ангилсан үзүүлэлтийн тоо	17.18.1 5.С.1

S5.8	Спортын хөтөлбөрөөр дамжуулан жендерийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор зорилтот санхүүжилт авч буй спортын байгууллага, гишүүн байгууллагуудын хувь, хуваарилсан нийт дүн	5.1-5.6
S5.9	Жендэрийн тэгш байдлыг хангах, спортоор дамжуулан эмэгтэйчүүд, охидыг чадавхижуулахад шууд хөрөнгө оруулалт хийсэн улсын спортын төсөв / спортын байгууллагын төсвийн хувь	3.4.1 5.A 5.1.1 10.3.1
S5.10	Хүүхэд болон охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр зорилтот санхүүжилт авч байгаа спортын байгууллага, гишүүн байгууллагын хувь, нийт төсөвлөсөн хэмжээ	5.2.2
S5.11	Охид, эмэгтэйчүүдийн спортод зарцуулдаг улсын спортын төсвийн хувь	3.4.1 5.1.1 10.3.1

ТХЗ 8: Тогтвортой, хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлт, хүн бүрийн бүрэн бөгөөд үр бүтээлтэй хөдөлмөр эрхлэлт, зохистой хөдөлмөрийг дэмжих

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Ангилал 1.

Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй, тогтвортой өсөлт, бүрэн ажил эрхлэлт, хүн бүрийн зохистой хөдөлмөрийг дэмжихтэй холбоотой үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 7: i) спортын үйл ажиллагаа, зугаа цэнгэл, амралт зугаалгын салбар, ii) спорт, фитнес, идэвхтэй амралт чөлөөт цагийн ДНБ-д оруулсан хувь нэмэр

Үзүүлэлт 8: спорт, фитнес, идэвхтэй амралт чөлөөт цагийн салбарын ажиллах хүчний хувь

Ангилал 2.

Эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй, тогтвортой өсөлт, бүрэн ажил эрхлэлт, хүн бүрийн зохистой хөдөлмөрийг дэмжихтэй холбоотой үзүүлэлтүүд:

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
S8.1	Спортын салбарт ажиллаж байгаа нэг хүнд ногдох салбарын жилийн өсөлтийн хувь	8.2.1
S8.2	15-29 насны боловсрол, ажил эрхлэлт, болон спортоор хичээллэж буй залуучуудын хувь	8.6.1 8.b.1
S8.3	ОУХБ-ын бичвэрийн эх сурвалж, үндэсний хууль тогтоомжид тулгуурлан хөдөлмөрийн эрхэд нийцсэн спортын томоохон арга хэмжээнүүд болон/ үндэсний спортын байгууллагуудын тоо	8.8.1 8.8.2
S8.4	Спорт болон улс орон бүрийн спортын тухай өргөн нэвтрүүлгийн болон дижитал эрхийн санхүүгийн үнэ	8.1 8.10
S8.5	Спортод зориулагдах нэвтрүүлгийн цагийн эзлэх хувь	8.1
		8.10
S8.6	Спортын арга хэмжээ тэмцээний маркетинг болон сурталчилгааны санхүүгийн үнэ	8.1 8.10
S8.7	Нийт аялал жуулчлалын салбарын ДНБ-д Идэвхтэй хөдөлгөөн, идэвхтэй амьдралын аялал зугаалгын ДНБ-ий эзлэх хувь	8.9.1
S8.8	Аялал жуулчлалын салбарын ажлын байранд спорт, идэвхтэй амьдралын чиглэлийн ажлын байрны тоо	8.9.2

S8.9	Спортын арга хэмжээнд оролцсон зочдын нийт хоногийн тоо (олон улс, бүс нутаг, дотоодын айлчлалаар ангилсан)	8.9.1
S8.10	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үр дүнг спортын хөтөлбөрөөр хангах зорилгоор зорилтот санхүүжилт авч буй байгууллагын тоо, хуваарилсан нийт дүн.	8.B.1
S8.11	i) спортын болон ii) холбоо бүхий тамирчдын тоо	8.6.1
S8.12	1) спортын томоохон арга хэмжээний эрх эзэмшигчид, 2) спортод зохистой ажлын байр бий болгох, инновацыг бий болгох, бизнес эрхлэхийг дэмжих, бичил, жижиг, дунд үйлдвэрүүдийг албан ёсны болгох, хөгжүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлдэг үндэсний спортын байгууллагын тоо	8.3
S8.13	Спортын арга хэмжээ зохион байгуулж байгаа хот/улсын ДНБ-ий үр нөлөө	8.1.1
S8.14	Томоохон спортын арга хэмжээг зохион байгуулсантай холбоотой худалдааны хэлцлийн тоо, өртөг (эсвэл томоохон спортын арга хэмжээг зохион байгуулсны дараах жилийн худалдааны хэлцлийн өсөлтийн үнэ цэнийг өмнөх жилтэй харьцуулахад)	8.3.1 8.4 8.A
S8.15	Томоохон спортын арга хэмжээг зохион байгуулсны дараа урт хугацаанд ашиглах талбай болон тоног төхөөрөмжид оруулсан хөрөнгө оруулалтын өртөг	11.7.1
S8.16	Спортын томоохон арга хэмжээг зохион байгуулахын тулд дотоодын ханган нийлүүлэгчидтэй хийсэн гэрээний үнийн дүн	8.1.1 17.17

ТХЗ 10: Улс орнуудын дотоод болон хоорондын тэгш бус байдлыг бууруулах

НИЙГМИЙН НӨЛӨӨЛӨЛ, ТЭГШ ЭРХ, ОРОЛЦОО

Ангилал 1:

Улс орнуудын дотор болон хоорондын тэгш бус байдлыг бууруулахтай холбоотой үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 1: Спорт, фитнес, идэвхтэй амралт зугаалгаар хичээллэх нь өөртөө болон гэр бүл, нийгэмд эерэг нөлөө үзүүлдэг хүн амын хувь

Үзүүлэлт 5: Долоо хоногт нэг удаа спорт, дасгал хийдэг эмэгтэйчүүдийн хувь

Үзүүлэлт 6: Хөгжлийн бэрхшээлтэй хүн долоо хоногт нэг удаа спорт, фитнес, идэвхтэй амралт (чөлөөт цаг)-т оролцсон тоо нийт хүн амтай харьцуулахад

Үзүүлэлт 9: Спортод сайн дурын ажил хийдэг хүн амын хувь

Үзүүлэлт 15: i] Тэргүүн, ii] Удирдах зөвлөлийн гишүүд, iii] Үндэсний спортын байгууллагуудын гүйцэтгэх захирал/Ерөнхий нарийн бичгийн дарга / эмэгтэй гишүүдийн гишүүн байгууллагуудын хувь

Үзүүлэлт 16: i) жендерийн тэгш байдлын стратеги, ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг спортод хамруулах стратегид хөрөнгө оруулалт хийсэн үндэсний спортын байгууллагууд / гишүүн байгууллагуудын хувь.

Ангилал 2:

Улс орнуудын доторх болон хоорондын тэгш бус байдлыг багасгахтай холбоотой үзүүлэлтүүд

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
S10.1	Хүйс, нас, боловсролын түвшин, үндэс угсаа, орлогоор нь ангилсан спорт, чийрэгжүүлэлт, идэвхтэй хөдөлгөөн хийдэг насанд хүрэгчид, өсвөр үеийнхний хувь	10.3.1
S10.2	Спортын тэгш байдал, оролцоог хангасан тодорхой бодлого бүхий үндэсний спортыг санхүүжүүлдэг гишүүн байгууллагуудын хувь	10.2 10.3
S10.3	Үндэсний спортын бодлогод эрх тэгш байдалд тусгахад чиглэсэн ажил	10.4
S10.4	Цагаачид, дүрвэгсэд, орогнол хүсэгчдийг үндэсний спортын бодлогод идэвхтэй оруулахад чиглэсэн ажил.	10.2
S10.5	Иргэдийн эмх цэгцтэй, аюулгүй, байнгын, хариуцлагатай шилжилт хөдөлгөөн, шилжилт хөдөлгөөнийг дэмжих зорилгоор спортод суурилсан арга хэмжээг ашиглах зорилгоор зорилтот санхүүжилт авч буй байгууллагын тоо, хуваарилсан нийт дүн	10.7.2
S10.6	Тэгш боломжийг дэмжих, үр дагаврын тэгш бус байдлыг бууруулахад спортод суурилсан оролцоог ашиглах, үүнд ялгаварлан гадуурхах практикийг арилгах, зохих арга хэмжээг дэмжих замаар зорилтот санхүүжилт авч буй байгууллагын тоо, хуваарилсан нийт дүн	10.3.1
S10.7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын төрөлд хуваарилагдсан нийт спортын төсвийн хувь (үндэсний төсвийн хөрөнгө, байгууллагын)	10.2.1
S10.8	Томоохон спортын арга хэмжээг зохион байгуулсны дараа иргэний бахархал, олон нийтийн эв нэгдлийг сайжруулсан тухай мэдээлсэн оршин суугчдын өөрчлөлтийн хувь (үйл явдлын өмнөх жилтэй харьцуулахад)	10.2
S10.9	Спортын томоохон арга хэмжээний ажилтнууд болон сайн дурын ажилтнуудыг хүйс, нас, орлогын түвшин, үндэс угсаагаар нь ангилсан тоо	10.3
S10.10	Хоцрогдсон бүлэг, цөөнхийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тэтгэлэг олгодог байгууллагуудын эзлэх хувь	16.1 16.B.1

ТХЗ 11: Хот, хүн амын суурьшлыг хүртээмжтэй, аюулгүй, уян хатан, тогтвортой болгох

НИЙГМИЙН НӨЛӨӨЛӨЛ, ТЭГШ ЭРХ, ОРОЛЦОО

Ангилал 1:

Ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 2: i) насанд хүрэгчид, ii) өсвөр насны хүн амын бие мах бодийн хувьд хангалттай идэвхтэй хүмүүсийн хувь

Үзүүлэлт 3: Долоо хоногт нэг удаа спорт, дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэг хүн амын хувь

Үзүүлэлт 10: Хүн амын спортын засаглалд сэтгэл хангалуун байгаа хувь

Үзүүлэлт 14: i) хүүхэд, ii) охид, эмэгтэйчүүдийг хамгаалах албан ёсны

бодлого (дэг журамтай) баталсан хувийн санхүүжилттэй үндэсний спортын байгууллагууд / гишүүн байгууллагууд

Үзүүлэлт 17: i) санхүүжилттэй үндэсний спортын байгууллагууд / гишүүн байгууллагууд ii) спортын томоохон байгууламжууд iii) уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд дасан зохицох, уур амьсгалд тэсвэртэй байдлыг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны стратеги бүхий томоохон арга хэмжээнүүд.

Үзүүлэлт 19: а) тамирчид б) дасгалжуулагч/албан тушаалтнууд, в) санхүүжилттэй үндэсний спортын байгууллага / гишүүн байгууллагуудын удирдлага/удирдах зөвлөлийн гишүүд. i) засаглал, спортын шударга байдал ii) хүүхэд, залуучууд, эмзэг бүлгийн хүмүүсийг хамгаалах, iii) эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, IV] тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр сүүлийн нэг жил бэлтгэгдсэн

Үзүүлэлт 21: Спорт, биеийн тамирын ерөнхий төлөвлөгөөтэй орон нутгийн засаг захиргаа / гишүүн байгууллагуудын хувь

Үзүүлэлт 23: Тогтвортой хөгжлийг дэмжихэд спорт, биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний оруулах хувь нэмэрт шууд оруулсан спортын төсвийн хувь

Ангилал 2:

Ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих үзүүлэлтүүд:

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
SI1.1	Спортын дэд бүтцэд хуваарилсан спортын төсвийн хувь Хөгжил дэвшил болон засвар техникийн үйлчилгээ	11.7.1
SI1.2	Хот суурин газарт спорт, амралт зугаалгын зориулалтаар олгосон газрын хувь	11.7.1
SI1.3	Спортын байгууламжийн төлөвлөлт, менежментэд шууд оролцдог үндэсний спортын байгууллага, гишүүн байгууллагуудын хувь	11.3.2 16.7
SI1.4	Хотын амьдрахад таатай орчин бүрдүүлэх спорт, арга хэмжээний дэд бүтцийг төлөвлөхөд оруулсан нийт хөрөнгө оруулалтын үнэ цэн, хөрөнгө оруулалтын эх үүсвэр	11.7.1
SI1.5	спорт клуб, спортын төв, сургууль, их дээд сургууль, эрүүл мэндийн болон фитнес төв зэрэг зориулалтын байгууламжийг ашигладаг хүмүүсийн хувь	11.7.1
SI1.6	Хүрээлэн буй орчны шаардлагад нийцсэн спорт болон биеийн идэвхтэй хөдөлгөөний төлөвлөгөөтэй орон нутгийн захиргааны хувь	11.7.1
SI1.7	Амьдардаг газар нь идэвхтэй хөдөлгөөн хийхэд тохиромжтой гэсэн хүмүүсийн хувь	11.7.1
SI1.8	Байгалийн гамшиг болон бусад урьдчилан тооцоолоогүй цаг уурын гамшигт тохиолдсон гамшгийн үеийн санхүүжилтэд хуваарилсан дэд бүтцийн төсөв хувь	13.1 13.3.2 15.b.1
SI1.9	Нийтийн тээврээр эсвэл sustainable transport-р очсон томоохон арга хэмжээний үзэгчдийн хувь	11.7
SI1.10	Нийтийн дэд бүтцийн үндсэн арга хэмжээний хөрөнгө оруулалт	11.2.1 11.7.1
SI1.11	Нийтийн тээврийн дэд бүтцэд оруулсан үндсэн арга хэмжээний нийт хөрөнгө оруулалт	11.2.1

ТХЗ 12: Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн хэв маягийг хангах

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Ангилал 1:

Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн хэв маягийг хангахтай холбоотой үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 13: i) carbon footprint, ii) дахин боловсруулалтын хувь хэмжээний жилийн хувийн өөрчлөлт: а) спортын томоохон байгууламжууд; б) спортын томоохон арга хэмжээнүүд

Үзүүлэлт 17: i) санхүүжилттэй үндэсний спортын байгууллагууд / гишүүн байгууллагууд ii) спортын томоохон байгууламжууд iii) уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд дасан зохицох, уур амьсгалд тэсвэртэй байдлыг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны стратеги бүхий томоохон арга хэмжээнүүд.

Үзүүлэлт 21: Спорт, биеийн тамирын ерөнхий төлөвлөгөөтэй орон нутгийн засаг захиргаа / гишүүн байгууллагуудын хувь

Ангилал 2:

Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн хэв маягийг хангахтай холбоотой үзүүлэлтүүд:

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
S12.1	1) спортын томоохон байгууламжууд, 2) спортын томоохон арга хэмжээнүүд, 3) үндэсний спортын байгууллагууд / тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй гишүүн байгууллагуудын хувь	12.1.1
S12.2	1) спортын томоохон байгууламжууд, 2) спортын томоохон арга хэмжээнүүд, 3) үндэсний спортын байгууллагууд / тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй гишүүн байгууллагуудын хувь	12.7.1
S12.3	1) спортын томоохон байгууламжууд, 2) спортын томоохон арга хэмжээнүүд, 3) үндэсний спортын байгууллагуудын гишүүн байгууллагуудын сүүлийн нэг жилийн тогтвортой байдлын тайланг нийтэлсэн хувь	12.6.1
S12.4	Спортын бодлого эсвэл хөтөлбөрийн хүрээнд тогтвортой хөгжлийн боловсролын ач холбогдлыг (уур амьсгалын өөрчлөлтийн боловсролыг оролцуулан) иш татсан үндэсний спортын байгууллага, гишүүн байгууллагуудын хувь	12.8.1
S.12.5	Байгаль орчин, тогтвортой байдлын талыг бэхжүүлэх зорилготой спортод суурилсан зан үйлийг өөрчлөх ажил	12.2.1 12.2.2
S.12.6	1. Дэд бүтцийг сайжруулах, 2. Спортын хөтөлбөр, спортын арга хэмжээг зохион байгуулах үр дүнд илүү тогтвортой үйлдвэрлэлийн хэв маяг руу шилжих шинжлэх ухаан, технологийн чадавхад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ.	12.A.1 12.8.1
S.12.7	Жилийн төлөвлөлтөд цаг уурын үнэлгээ, хариу арга хэмжээг тусгасан үндэсний спортын байгууллагууд, гишүүн байгууллагуудын хувь.	12.7.1 12.b.1
S.12.8	Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бодлоготой үндэсний спортын холбоо, гишүүн байгууллагын хувь, жилийн төсөвт тусгагдсан хэмжээ.	12.1 12.4.1 12.7.1 12.B.1

S.12.9	Сэргээгдэх эх үүсвэрээс авдаг томоохон арга хэмжээний эрчим хүчний хувь	12.6.1
S12.10	Тогтвортой байдлын стандартад нийцсэн томоохон спортын арга хэмжээнд олгосон гэрээний хувь	12.7.1
S12.11	Үндсэн арга хэмжээний нүүрстөрөгчийн саармаг байдал, томоохон спортын арга хэмжээний нүүрстөрөгчийн ул мөрийн нөхөн олговор	12.5.1 12.6.1
S12.12	Амьдралын хэв маягаа өөрчилсөн, хүрээлэн буй орчинд тустай үйл ажиллагаа явуулах хүсэлтэй байгаагаа мэдээлсэн спортын томоохон арга хэмжээнүүд болон оролцогчдын хувь	12.8

ТХЗ 13: Уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөллийн эсрэг яаралтай арга хэмжээ авах

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Ангилал 1:

Уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөллийн эсрэг яаралтай арга хэмжээ авахтай холбоотой үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 13: i) carbon footprint, ii) дахин боловсруулалтын хувь хэмжээний жилийн хувийн өөрчлөлт: а) спортын томоохон байгууламжууд; б) спортын томоохон арга хэмжээнүүд

Үзүүлэлт 17: i) санхүүжилттэй үндэсний спортын байгууллагууд / гишүүн байгууллагууд ii) спортын томоохон байгууламжууд iii) уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд дасан зохицох, уур амьсгалд тэсвэртэй байдлыг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааны стратеги бүхий томоохон арга хэмжээнүүд.

Үзүүлэлт 21: Спорт, биеийн тамирын ерөнхий төлөвлөгөөтэй орон нутгийн засаг захиргаа / гишүүн байгууллагуудын хувь

Ангилал 2:

Уур амьсгалын өөрчлөлт, түүний нөлөөллийн эсрэг яаралтай арга хэмжээ авахтай холбоотой үзүүлэлтүүд:

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
S13.1	Тогтвортой арга хэмжээний менежментийн ISO 20121 стандартыг хангасан спортын томоохон арга хэмжээний хувь	13.2.1
S13.2	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зохих арга хэмжээнд нийцсэн томоохон хэмжээний спортын дэд бүтцийн хувь	13.2.1
S13.4	Спортын үндэсний бодлогод уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд дасан зохицох салбарын чадавхыг нэмэгдүүлэх, уур амьсгалын хамаарал, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах нэгдсэн стратеги төлөвлөгөө багтана.	13.2.1 13.3.1 13.3.2
S13.5	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, нөлөөллийг бууруулах, урьдчилан сэрэмжлүүлэх чиглэлээр боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, хүний болон байгууллагын чадавхыг	13.3.1

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
	дэмжихэд спортод суурилсан арга хэмжээг ашиглах зорилгоор төсвийн зорилтот санхүүжилт авч буй байгууллагуудын хувь, хуваарилсан нийт дүн	
S13.6	Уур амьсгалын онцгой байдлын үед спортын байгууллага, байгууламжид нэвтрэх боломжтой гэнэтийн санхүүжилт эсвэл яаралтай тусламжийн санхүүжилтийн хэмжээ	13.3.2 13.A.1
S13.7	Уур амьсгалын өөрчлөлт, онцгой байдлын үед даатгуулсан спортын байгууллага болон гишүүн байгууллага, спортын байгууламжийн хувь	13.3.2

ТХЗ 16: Тогтвортой хөгжлийн төлөө энх тайванч, хүртээмжтэй нийгмийг дэмжих, хүн бүрт шударга ёсны хүртээмжийг олгох, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, хүртээмжтэй байгууллагуудыг бий болгох

ЗАСАГЛАЛ

Ангилал 1.

Тогтвортой хөгжлийн төлөө энх тайван, хүртээмжтэй нийгмийг дэмжих, шударга ёсыг хүн бүрт хүртээмжтэй болгох, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, хүртээмжтэй институцуудыг бий болгохтой холбоотой үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 10: Хүн амын спортын засаглалд сэтгэл хангалуун байгаа хувь

Үзүүлэлт 14: i) хүүхэд, ii) охид, эмэгтэйчүүдийг хамгаалах албан ёсны бодлого (дэг журамтай) баталсан хувийн санхүүжилттэй үндэсний спортын байгууллагууд / гишүүн байгууллагууд

Үзүүлэлт 15: i] Тэргүүн, ii] Удирдах зөвлөлийн гишүүд, iii] Үндэсний спортын байгууллагуудын гүйцэтгэх захирал /Ерөнхий нарийн бичгийн дарга / эмэгтэй гишүүдийн гишүүн байгууллагуудын хувь

Үзүүлэлт 18: i) тамирчид, үзэгчид, ажилчид болон холбогдох бусад бүлгүүдийн эрхийг хамгаалах, ii) спортын тэмцээн уралдааныг хууран мэхлэхээс сэргийлэх арга хэмжээг чангатгах, iii) албан ёсны бодлого (дэг журамтай) баталсан үндэсний спортын байгууллагууд /гишүүн байгууллагуудыг санхүүжүүлдэг.), допингийн эсрэг зохих бодлогын тогтолцоо, түүний хэрэгжилт, дагаж мөрдөх үр дүнтэй арга хэмжээг хангах, спортын бүрэн бүтэн байдлыг хамгаалах

Үзүүлэлт 20: i] хүүхэд хамгаалах, ii] охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулахад хувь нэмэр оруулсан үндэсний спортын байгууллагууд / нэр дэвшүүлсэн төвлөрсөн байгууллагатай гишүүн байгууллагууд

Үзүүлэлт 21: Спорт, биеийн тамирын ерөнхий төлөвлөгөөтэй орон нутгийн засаг захиргаа / гишүүн байгууллагуудын хувь

Үзүүлэлт 22: Спортод оруулсан улсын төсвийн зардлын хувь

Үзүүлэлт 23: Тогтвортой хөгжлийг дэмжихэд спорт, биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний оруулах хувь нэмэрт шууд оруулсан спортын төсвийн хувь

Ангилал 2.

Тогтвортой хөгжлийн төлөө энх тайван, хүртээмжтэй нийгмийг дэмжих, шударга ёсыг хүн бүрт хүртээмжтэй болгох, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, хүртээмжтэй институцуудыг бий болгохтой холбоотой үзүүлэлтүүд:

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
S16.1	Амьдарч буй газрынхаа эргэн тойронд ганцаараа алхахдаа аюулгүй гэж боддог хүн амын эзлэх хувь.	16.1.4
S16.2	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ИНДЕКС: Спортын ардчиллын нийтлэг индекс 1 Дэлгэрэнгүй мэдээллийг Протоколын хуудаснаас үзнэ үү	ТХЗ: 16.4 16.5 16.6 16.7
S16.3	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ИНДЕКС: 15 үзүүлэлтийн индекс: - Спортын ил тод байдал (2) Дэлгэрэнгүй мэдээллийг Протоколын хуудаснаас үзнэ үү	ТХЗ: 16.4 16.5 16.6 16.7
S16.4	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ИНДЕКС: 15 үзүүлэлтийн индекс: - Спортын шударга байдал (2) Дэлгэрэнгүй мэдээллийг Протоколын хуудаснаас үзнэ үү	ТХЗ: 16.4 16.5 16.6 16.7
S16.5	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ИНДЕКС: 15 үзүүлэлтийн индекс: - Спортын хөгжил болон эв нэгдэл Дэлгэрэнгүй мэдээллийг Протоколын хуудаснаас үзнэ үү	ТХЗ: 16.4 16.5 16.6 16.7
S16.6	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ИНДЕКС: 15 үзүүлэлтийн индекс: - дотоод механизм, хяналт 5 Дэлгэрэнгүй мэдээллийг Протоколын хуудаснаас үзнэ үү	ТХЗ: 16.4 16.5 16.6 16.7
S16.7	Спортоор дамжуулан хүчирхийллийг бууруулах, шийдвэрлэх хөтөлбөртэй үндэсний спортын байгууллагуудын хувь	16.1.3 16.1.4
S16.8	Хүчирхийлэл, нийгмийн эсрэг зан үйлийг бууруулах, шийдвэрлэхэд спортод суурилсан арга хэмжээг ашиглах зорилгоор төсвийн зорилтот санхүүжилт авч буй байгууллагуудын хувь, хуваарилсан нийт дүн	16.1.3
S16.9	Спортын томоохон арга хэмжээний үеэр гэмт хэргийн гаралт өмнөх жилтэй харьцуулахад хувиар өөрчлөгдсөн	ТХЗ: 16.1
S16.10	Спорт, биеийн тамирын хөтөлбөртэй хорих анги, хүмүүжүүлэх байгууллагын хувь	16.1.3 16.1.4
S16.11	Match fixing гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрүүгийн хуулийн заалт байгаа эсэх, хэрэглэгдэх байдал	16.4.1
S16.12	Спортоор дамжуулан хууль бус хөрөнгийн урсгалыг бууруулах бодлого, арга хэмжээ	16.4.1

ТХЗ 17: Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхийн түншлэлийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг бэхжүүлж идэвхжүүлнэ.

ЗАСАГЛАЛ

Ангилал 1.

Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхийн түншлэлийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг бэхжүүлэх, идэвхжүүлэхтэй холбоотой үзүүлэлтүүд:

Үзүүлэлт 22: Спортод оруулсан улсын төсвийн зардлын хувь

Үзүүлэлт 23: Тогтвортой хөгжлийг дэмжихэд спорт, биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний оруулах хувь нэмэрт шууд оруулсан спортын төсвийн хувь

Ангилал 2.

Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхийн түншлэлийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг бэхжүүлэх, идэвхжүүлэхтэй холбоотой үзүүлэлтүүд:

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
SI7.1	ТХЗ-ын тэргүүлэх зорилтуудтай зориудаар нийцсэн үндэсний спортын бодлогын зорилтуудын хувь	17.14.1
SI7.2	Спортын тусгайлсан хамтын ажиллагааны санаачилгад төрийн байгууллага, иргэний нийгмийн түншлэлийн хувь	17.9 17.17
SI7.3	Стратегийн төлөвлөгөөндөө үндэсний хөгжлийн төлөвлөгөө болон эсвэл ТХЗ-ыг тусгасан үндэсний спортын байгууллагуудын хувь	17.14.1
SI7.4	Үндэсний статистикийн төлөвлөгөө хүрээнд багтсан спорт, биеийн тамир, биеийн тамиртай холбоотой үзүүлэлтүүдийн хувь	17.16.1 17.18.1
SI7.5	Улсын тооллого, өрхийн зарлагын судалгаанд хамрагдсан спорт, биеийн тамирын боловсрол, идэвхтэй хөдөлгөөний асуулгын хувь	17.16.1 17.19.2
SI7.6	Спорт болон идэвхтэй хөдөлгөөн үндэсний стратеги төлөвлөгөөнд хяналт тавих үйл ажиллагааны үндэсний салбар хоорондын хороо зохицуулах механизм нь тэдний хяналтын үүрэг хариуцлага...	17.14.1
SI7.7	(SDP)Энх тайван болон хөгжлийн төлөөх спортын талаарх ойлголтыг хуваалцах үндэсний мэдлэг солилцох, суралцах форум хэр зэрэг байдаг	17.14.1
SI7.8	Спорт, биеийн тамир, идэвхтэй дасгал хөдөлгөөнтэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг албан ёсоор бүртгэлтэй ТББ-ын хувь ((SDP) оролцогчдыг хамруулаад)	17.17.1
SI7.9	Тухайн улсын спортын байгууллагаас гаргасан спорт, биеийн тамирын боловсрол, идэвхтэй хөдөлгөөнтэй холбоотой судалгааг агуулсан магадлан итгэмжлэгдсэн эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн нийтлэлийн хувь	17.6 17.9 17.14 17.17
SI7.10	Спортод холбоотой төслүүдэд хөрөнгө хуваарилж буй спортын бус яам, хэлтэс, хуулийн байгууллагуудын хувь	17.17.1
SI7.11	Төсвийн зорилтот санхүүжилт авч, хуваарилсан нийт дүнгийн талаар тайлагнаж буй байгууллагуудын хувь нь тодорхой ТХЗ-ын эсрэг хэрэгжүүлэхийн тулд спортод суурилсан интервенцийг ашигладаг.	17.17.1 17.2.1
SI7.12	1) үндэсний спортын байгууллагууд, 2) арилжааны орлогоос санхүүжүүлсэн спортын томоохон арга хэмжээний төсвийн төсөв, улсын буцалтгүй тусламжийн эзлэх хувь	17.12 17.17

Код	Тодорхой шалгуур үзүүлэлт	ТХЗ-ын уялдаа холбоотой үзүүлэлт
S17.13	Тулгамдсан хөгжлийн зорилтод спортын байгууллага, гишүүн байгууллагуудын нөөцийн ил тод хуваарилалтыг тодорхойлох тодорхой бодлого баримтална.	17.3.1
S17.14	Үндэсний хөгжлийн төлөвлөгөө болон ТХЗ-д хамаарах зорилго, зөвшөөгдсөн зорилтуудыг зохион байгуулах томоохон спортын арга хэмжээний хувь	17.14.1
S17.15	Томоохон спортын арга хэмжээний төсөвт оруулсан хувь нэмрийг улсын байгууллагаас оруулсан хувь	17.17.1 17.17.1
S17.16	Спортын салбарын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийн харьцаа (эдийн засгийн нийт өгөөжийг улсын хөрөнгө оруулалтад хуваасан).	8.1.1 17.1.1

12. ДҮГНЭЛТ

1. Биеийн тамир, спортын бодлогод идэвхтэй амьдрал бүхий иргэн, гэр бүлийг зорилго болгожээ. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Амьдралын чанар ба дундаж давхарга” гуравдугаар бүлгийн зорилгыг хангахын тулд ЗГ-аас дунд хугацаанд биеийн тамир, спортын салбарын бодлогын чиглэлийг **“Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.”** гэж тусган хэрэгжүүлж байна.

2. Биеийн тамир, спортын салбарын зорилтуудыг хэрэгжүүлснээр Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) 2030-ын бусад олон зорилгыг биелүүлэхэд хувь нэмэр болно. Биеийн тамир, спортоор дамжуулан хамгаалах, сурталчлах нь ТХЗ-ын аюулгүй, тогтвортой хот, чанартай боловсрол, зохистой хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн өсөлт, тэгш бус байдлыг бууруулах, хүрээлэн буй орчныг хамгаалах, жендерийн тэгш байдал, энх тайван, хүртээмжтэй хөгжлийг дэмжих зэрэг бусад олон ТХЗ-д шууд хувь нэмэр оруулах юм. Тогтвортой хөгжлийн 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлтэд спорт, идэвхтэй хөдөлгөөнтэй шууд холбогдох үзүүлэлт байхгүй ба Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягт Зорилт 3.5. Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийн дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ гэж тусгасан байна.

3. МУ-ын биеийн тамир, спортын салбарын дунд ба урт хугацааны бодлогын зорилго, зорилтуудын үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт хангалтгүй байна. Алсын хараа 2050, МУ-ыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан биеийн тамир, спортын зорилтуудын хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд нь үр дүн, үр нөлөөний шалгуур үзүүлэлт бус гарц, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хэмжих шинж чанартай шалгуур үзүүлэлтүүд байна.

4. Биеийн тамир, спортын салбарын тогтолцоо тогтворгүй байжээ. Тайлант хугацаанд дөрвөн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд төсөв нь батлагдаж, гүйцэтгэлээ тайлагнаж ирсэн байна. Өөрөөр хэлбэл соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд гэсэн нийт 3 салбартай хамт биеийн тамир, спортын салбарын эрхлэх асуудал хамрагдаж ирсэн байна. Энэ нь тухайн салбартай холбоотой төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг боловсруулахад хүндрэлтэй байв.

5. Тус салбарт ажиллагчдын тоо нэмэгдсэн байна. Нийт ажиллагчид болон байгууллагын тоо өмнөх оноос өссөн гол шалтгаан нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороог байгуулах тушаалаар Биеийн тамир, спортын улсын хороог байгуулсантай холбоотой юм. Нийт ажилчдын 46.3%-ийг захиргаа, санхүүгийн болон үйлчилгээ, аж ахуйн ажилтан эзэлж байна.

6. Салбарын төсвийн зарлагыг ДНБ-тэй харьцуулахад 2012 онд 0.4 хувьтай байна. Биеийн тамир, спортын салбарын батлагдсан төсвийн гүйцэтгэл 2012 онд 63.8 тэрбум төгрөг байсан бол 2022 онд гүйцэтгэл 61.8 тэрбум төгрөг болсон байна. Салбарын төсвийн зарлагыг ДНБ-тэй харьцуулахад 2012 онд 0.4 хувь байсан бол 2022 онд 0.1 хувь болж 0.3 нэгжээр буурсан байна. /Зураг 10/ Салбарын зарлагын ДНБ-тэй харьцуулсан харьцаа буурсан шалтгаан нь тухайн хугацаанд ДНБ нэрлэсэн үнээр 16.7 их наядаас 54.9 их наяд болж 3.3 дахин өссөн байна.

7. Биеийн тамир, спортын салбарын Салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг анх баталсан төсөвтэй нь харьцуулахад сүүлийн 3 жилийн хугацаанд төсвийн найдвартай байдал “сайн” байна. Салбарын харьяа байгууллагаар баталсан төсвийн гүйцэтгэлийн зөрүүний дундаж хувь байгууллагын хувьд 2020 онд 14.4%, 2021 онд 13.7%, 2022 онд 2.6% тус тус байжээ. Түүнчлэн батлагдсан төсөв ба гүйцэтгэлийн зөрүүний нийт зарлагад эзлэх хувь 2020 онд 17.2%, 2021 онд 3.1%, 2022 онд 2.4% тус тус байна. 2020 онд Ковидын нөхцөл байдлын улмаас хөл хорио тогтоосонтой холбоотойгоор батлагдсан төсвөө гүйцэд зарцуулж чадаагүй байна. Харин 2021, 2022 онд байгууллагуудын төсвийн гүйцэтгэл сайн байна. Салбарын батлагдсан төсөв ба гүйцэтгэлийг байгууллагаар, эдийн засгийн ангиллаар үзэхэд хөрөнгө оруулалтын зардлын дутуу гүйцэтгэл нь төсвийн гүйцэтгэлд хамгийн их нөлөө үзүүлж байна.

8. Салбарын харьяа байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 2022 онд нэмэгдсэн байна. Цар тахлын үеийн хөл хорио үргэлжилсэн 2020, 2021 онд төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлого бага байсан бол 2022 онд өсөж, 552.3 сая төгрөгийн орлого олсон байна.

9. Биеийн тамир, спортын хөтөлбөрийн 23.1 хувийг “биеийн тамир, спортын арга хэмжээ” зориулалтад зарцуулж байна. 2020, 2021, 2022 оны төсвийн гүйцэтгэлээс харахад хамгийн их төсөв зарцуулсан арга хэмжээ нь улсын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих зардалд нийт 26.0 тэрбум төгрөг зарцуулсан байна. 2020 онд олон улсын залуучуудын ногоон наадам арга хэмжээнд 9.6 тэрбум төгрөгийг нэг удаа зарцуулсан байна. Мөн Олимп ДАШТ-с медаль авсан тамирчдын урамшуулалд нийт 5.0 тэрбум төгрөг, жилд дунджаар 1.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

10. Салбарын урсгал зардлын болон хөрөнгө оруулалтын төсвийн хэлбэлзэл маш өндөр байна. Урсгал зардал 2019 онд 49.8%-иар өмнөх оноос буурсан бол 2020 онд 115.7%-иар нэмэгдсэн байх бөгөөд харин хөрөнгө оруулалтын зардал 2017 онд 63.5%-иар өмнөх оноос буурсан бол 2018 онд 130.9%-иар нэмэгдсэн байна.

11. Салбарын нийт зардлын 56.1 хувийг хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна. Нийт урсгал зардлын хувьд БТСГ 43.7%, БТСУХ 52.4%-ийг эзэлж байна. 2012-2022 оны хугацаанд салбарын нийт урсгал зардлын дунджаар 63.7%-ийг бараа үйлчилгээний зардал, 33.1%-ийг урсгал шилжүүлэгт зарцуулсан бол салбарын 2012-2022 оны бараа үйлчилгээний зардалд цалин хөлс, НДШ-ийн зардлын эзлэх хувь дунджаар 31.7 хувь байна.

12. Биеийн тамир, спортын салбарт 2010-2023 онд хөрөнгө оруулалтын нийт 172 барилга байгууламж барих, их засвар, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний төсөв батлагдаж гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байна. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг тухайн онд батлагдсан санхүүжих дүнтэй харьцуулахад 2010-2022 оны хугацаанд 85.4% байна. Хөрөнгийн төсвийн гүйцэтгэл 2019 онд 53.2%-тай хамгийн бага байсан бол 2022 онд сайн буюу 98.7% гүйцэтгэлтэй гарсан байна.

13. Салбарын хувьд 2020-2022 оны тайлант хугацаанд авлага 1.6 тэрбум төгрөгөөр буурсан бол, өглөг 5.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Биеийн тамир, спортын салбар 2022 оны жилийн эцсийн байдлаар 1.8 тэрбум төгрөгийн авлагатай болсон нь 2021 онтой харьцуулахад 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт өр төлбөрийн хувьд 2022 оны санхүүгийн тайлангаар 6.9 тэрбум төгрөгийн өр төлбөртэй гарсан бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 2.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

14. Биеийн тамир, спорт хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай байна. Нийтийн биеийн тамирыг дэмжих зардлыг нэмэгдүүлэхэд биеийн тамираар хичээллэгчдийн тоо 0.49 коэффициентоор нэмэгдэхээр байна. Харин олон улсын тэмцээн, уралдаанд оролцох зардал нь олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоотоо урвуу, дундаж хамааралтай /0.5513/ байгаа нь “Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо” гэсэн шалгуур үзүүлэлтийг буруу төлөвлөсөнтэй холбоотой бөгөөд шалгуур үзүүлэлтийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

13. ЗӨВЛӨМЖ

1. Биеийн тамир, спортын салбарын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэх. Харьяа байгууллагуудаас авдаг захиргааны тоо мэдээллийг сайжруулах, албан ёсны статистик үзүүлэлтүүдийг шинэчлэх, хувийн хэвшилд ажиллагчдын тооны статистик мэдээлэл зэргийг тооцдог болох шаардлагатай байна.

2. Биеийн тамир, спортын салбарын хөтөлбөрийн төрлийг оновчтой тодорхойлж, зориулалт, арга хэмжээний ангиллыг сайжруулах. Салбарын хөтөлбөрийг “Биеийн тамир, спорт” гэсэн өнөөгийн түвшинд хэвээр нь хадгалан хэрэглэж, харин хөтөлбөрийн гарцыг шинэчлэн тусгах шаардлагатай байна. Цаашид төвлөрсөн зардлуудын төсвийг холбогдох зардлыг гарц, зориулалт, арга хэмжээгээр салгаж төсвийг батлуулан, урьдчилан төлөвлөдөг байх нь зүйтэй байна. Ингэснээр хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж, дэвшүүлсэн зорилтдоо хүрч байгаа эсэхийг хянах боломжтой болно.

3. Салбарын хөрөнгийн зардлын гүйцэтгэлийг сайжруулах. Биеийн тамир, спортын салбарын төсвийн зарлагын гүйцэтгэлийг анх баталсан төсөвтэй нь харьцуулан үнэлэхэд төсвийн найдвартай байдал “сайн” байна. Гэхдээ салбарын батлагдсан төсөв ба гүйцэтгэлийг байгууллагаар болон эдийн засгийн ангиллаар харахад хөрөнгө оруулалтын зардлын дутуу гүйцэтгэл нь төсвийн гүйцэтгэлд хамгийн нөлөө үзүүлж байна. Барилга байгууламжийн ашиглалтад орох хугацаа төлөвлөснөөс хойшлох нь төсөвт өртөг нэмэгдэх гол хүчин зүйл болж эдийн хувьд үр ашиггүй нөхцөл байдал үүсдэг. Иймд төсөл арга хэмжээний ТЭЗҮ-ийг анхнаас нь зөв тодорхойлж, ач холбогдлоор нь эрэмбэлж, шаардлагатай төсөлд л хөрөнгө оруулалт хийхдээ архитектор дизайны орчин үеийн шийдлийг харгалзан үзэх нь зүйтэй байна.



АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

European Union. (2019). Appendix. *Manual on sources and methods for the compilation of COFOG statistics*. Д Luxembourg: Publications Office of the EU.

PEFA Secretariat. (2019). *Framework for Assessing Public Financial Management. Second Edition*. Washington DC: PEFA. PEFA.-ээс Гаграсан

Robinson, M. (2013). *Classification for Performance-Based Budgeting: How to Structure Budgets to Enable the Use of Evidence*. Washington, DC: World Bank.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. (2021). *Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичиг болон Тогтвортой хөгжлийн зорилго хоорондын уялдаа, тойм шинжилгээ: Үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж*. Улаанбаатар: НҮБХХ.

UNESCO. (2023). *Impact Investment in Sport. Innovating the Funding of Sport for Development*.

The Commonwealth. (2020). *Sport and SDG Indicators: Category 2 Indicators v4.0 Draft*

The Commonwealth. (2020). *Measuring the contribution of sport, physical education and physical activity to the Sustainable Development Goals: Sport & SDG Indicator Toolkit V4.0*

